

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 05-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2023 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 05-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААН



ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 05-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2023 оны 04 дүгээр сарын 05-ны өдөр, Лхагва гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	1-2
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	3-29
1. Төрийн албаны зөвлөлийн 2021, 2022 оны үйл ажиллагааны тайланг сонсох	3-29

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 05-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы
Төрийн байгуулалтын байнгын хорооны 04 дүгээр сарын 05-ны өдөр
/Лхагва гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Н.Энхболд ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 19 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 52.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 11 цаг 14 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Чөлөөтэй: С.Амарсайхан, Х.Нямбаатар, Л.Оюун-Эрдэнэ;
Эмнэлгийн чөлөөтэй: Ж.Сүхбаатар.

Хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Ш.Адъяаа оролцов.

Нэг. Төрийн албаны зөвлөлийн 2021, 2022 оны үйл ажиллагааны тайланг сонсох

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Төрийн албаны зөвлөлийн дарга Б.Баатарзориг, мөн зөвлөлийн гишүүн Ц.Амартөгс, Д.Баатарсайхан, Б.Идэрчулуун, С.Цэдэндамба, Ажлын албаны дарга Г.Билгүүн, Сонгон шалгаруулалтын газрын дарга Т.Сосорбарам, Маргаан хянан шалгах газрын дарга Ч.Бат-Эрдэнэ, Захиргаа, удирдлагын газрын дарга В.Жавзан, референт Э.Золбоо, Судалгаа мэдээллийн нэгдсэн сангийн газрын ахлах референт Л.Лхамжав, Хүний нөөцийн удирдлага, аудитын газрын шинжээч Д.Бишүүгарам нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох, Хяналт шалгалт, үнэлгээний газрын дарга Ц.Батбаатар, мөн газрын Хяналт шалгалтын хэлтсийн дарга Ж.Лхагвасүрэн, ахлах зөвлөх Ч.Онончимэг, Захиргаа, хүний нөөцийн хэлтсийн дарга Б.Пүрэвдагва нар байлцав.

Төрийн албаны зөвлөлийн 2021, 2022 оны үйл ажиллагааны талаар Төрийн албаны зөвлөлийн дарга Б.Баатарзориг, Төрийн албаны зөвлөлийн 2021, 2022 оны үйл ажиллагааны тайланд Улсын Их Хурлын Тамгын газрын Хяналт шалгалт, үнэлгээний газрын хийсэн хяналт, шалгалтын талаарх дүгнэлтийг Хяналт шалгалтын хэлтсийн дарга Ж.Лхагвасүрэн нар танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар, Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэг, А.Адъяасүрэн, Ш.Адъяаа нарын тавьсан асуултад Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Н.Энхболд, Төрийн албаны зөвлөлийн дарга Б.Баатарзориг, мөн зөвлөлийн гишүүн Ц.Амартөгс, Д.Баатарсайхан, Б.Идэрчулуун нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар, Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Н.Энхболд нар үг хэлэв.

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 05-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

Улсын Их Хурлын гишүүд Төрийн албаны зөвлөлийн 2021, 2022 оны үйл ажиллагааны талаар Төрийн албаны зөвлөлийн дарга Б.Баатарзоригийн мэдээллийг сонсов.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 1 цаг 41 минут үргэлжилж, 19 гишүүнээс 15 гишүүн хүрэлцэн ирж, 78.9 хувийн ирцтэйгээр 12 цаг 55 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

**ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА**

Н.ЭНХБОЛД

Тэмдэглэл хөтөлсөн:

**ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ ХӨТЛӨХ
АЛБАНЫ ШИНЖЭЭЧ**

П.ОЮУНГЭРЭЛ

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 05-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2023 оны 04 дүгээр сарын 05-ны өдөр,
Лхагва гараг
Төрийн ордон “Жанжин
Д.Сүхбаатар” танхим
11 цаг 14 минут.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2023
ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ
ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН
БАЙНГЫН ХОРООНЫ 04 ДҮГЭЭР
САРЫН 05-НЫ ӨДӨР /ЛХАГВА
ГАРАГ-ИЙН ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

Н.Энхболд: Байнгын хорооны гишүүдийн ирц бүрдсэн байна.

ТББХ-ны 23 оны 4 сарын 05-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Хэлэлцэх асуудал танилцуулъя. Өнөөдрийн байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэнэ.

Монгол Улсын ТАЗ-ийн үйл ажиллагааны 21, 22 оны тайлан сонсоно. Хуулиар ТАЗ-ийн тайланг ТББХ-ны хурлаар сонсож дүгнэлт гаргаж байх учиртай.

Хэлэлцэх асуудалтай холбоотой саналтай гишүүн байна уу? Алга байна.

Хэлэлцэх асуудалдаа оръё.

Ажлын хэсгийн гишүүдийг оруулчихъя. Өнөөдрийн хуралдаанд оролцох ажлын хэсгийн хүмүүсийг танилцуулъя.

ТАЗ-ийн дарга Баатарзориг, ТАЗ-ийн гишүүн Амартөгс, ТАЗ-ийн гишүүн Цэдэндамбаа байна уу? Ирсэн байна, ТАЗ-ийн гишүүн Баатарсайхан, ТАЗ-ийн гишүүн Идэрчулуун бүгд ирсэн байна. Мөн УИХ-ын Тамгын газрын Хяналт шалгалтын хэлтсийн дарга Лхагвасүрэн, ТАЗ-ийн ажлын албаны дарга Билгүүн,

мөн зөвлөлийн Сонгон шалгаруулалтын газрын дарга Сосорбарам, зөвлөлийн Маргаан хянан шалгах газрын дарга Бат-Эрдэнэ, ТАЗ-ийн Захиргаа удирдлагын газрын дарга Жавзан, зөвлөлийн Судалгаа, мэдээллийн нэгдсэн сангийн газрын ахлах референт Лхамжав, зөвлөлийн Захиргаа удирдлагын газрын референт Золбоо, зөвлөлийн Хүний нөөцийн удирдлага аудитын газрын шинжээч Бишүүгарам. Ажлын хэсгийн гишүүд бүгд ирсэн байна.

Энэ удаагийн хуралдаанаар бид 21 оны тайланг бас хэлэлцээгүй байсан. 21, 22 оны тайлангаа хамтатгаад хэлэлцье гэсэн ийм шийдвэртэй байгаа. Тусгайлан заасан тайлан илтгэл мэдээллийг УИХ-д ирүүлж байх ёстой. 21 оных хугацаандаа ирсэн байсан, зүгээр хэлэлцээгүй одоо болтол хүрсэн юм байна лээ. ТББХ-нд жил бүр ирүүлж байх ёстой.

Ингээд ажилдаа орцгооё. Баатарзориг даргыг урьж байна. Монгол Улсын ТАЗ-ийн үйл ажиллагааны 21, 22 оны тайлангийн танилцуулгыг гишүүдэд тараачихсан байгаа. Тэгээд товч танилцуулъя. Баатарзориг даргын микрофоныг 4 номерын микрофон.

Б.Баатарзориг: Та бүхний өдрийн мэнд хүргэе. Монгол УИХ-ын дарга аа, Монгол Улсын ТББХ-н дарга аа, эрхэм гишүүд ээ, ТАЗ-ийн тайланг Байнгын хорооны улирлын эхний хуралдаанаар авч хэлэлцэж буйд УИХ, төрийн албаны шинэтгэлийн үйл явцад ач холбогдол өгч байна хэмээн хүлээж авч талархалтай байна.

Жил жилийн үйл ажиллагааны тайлангаа хуулийн хугацаанд УИХ-д хүргүүлж ирсэн уламжлалтай. 22 оны тайлангийн үр дүнгээс УИХ-ын даргад тусгайлан танилцуулсан болно. Энэ удаагийн тайлан нь 226 нүүр хуудас бүхий ном хэлбэрээр хэвлэгдэж, УИХ-ын эрхэм гишүүд та бүхэнд болон Байнгын хороодод хүргүүлсэн болно. Зөвлөлийн цахим хуудаст нийтэд ил тод мэдээлэл нээлттэй тавигдсан билээ.

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 05-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

ТАЗ-ийн 2021, 20 оны үйл ажиллагааны зарим онцлох үр дүнг та бүхэнд танилцуулъя. Та бүхэн анхаарлаа хандуулахыг хүсье.

Нэгдэх үр дүн. Ур чадварын шилжилт хийх эрх зүйн үндэс бүрдлээ. Хууль хэрэгжүүлэх эхний жилүүдийн сорилт, сургамжид үндэслэн Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт орсноор төрийн албаны албан тушаалын ангилал хооронд ур чадварын шилжилт хийх эрх зүйн үндэс бүрдсэн юм. Хуулийн энэ өөрчлөлтийн дагуу ТАЗ шинээр 8 журмыг боловсруулж баталснаас гадна өмнө нь мөрдөгдөж байсан 47 журам, дүрмүүдэд шинэчлэлт хийж байна. Төрийн албаны өөр өөр ангиллын албан тушаалуудыг адилтгах, ажилласан хугацааг дүйцүүлэн тооцох болсноор ажилтны ур чадвар, туршлагыг сэлгэх, шилжүүлэх, хүний нөөцийн нөхөн хангалтыг тэлэх боломж нээгдэж, төрийн албанд тулгарч буй хүний нөөцийн хомсдолыг тодорхой хэмжээгээр нөхөх боломж бүрдэж байгаа юм.

2. Сонгон шалгаруулалт цахимжлаа. Сонгон шалгаруулалтын тогтолцоог боловсронгуй болгох замаар хөгжлийн хөтөлгөгч хүч болох ур чадвартай нөөцийг бүрдүүлэхэд хувь хүний ёс суртахуун, зан төлөв, туршлага чадварыг үнэлж, зөв хүнийг шилж олох, шилж сонгох, томилох аргачлалыг олон улсын түвшинд хүргэхээр хичээн ажиллаж байна. Үр дүнгийн эхлэлүүд ч байна. Тайлант онд төрийн албаны ерөнхий шалгалтыг улирал бүхэн зохион байгуулж эхэллээ. Өмнө нь жилд 1 удаа зохион байгуулж байсан. Төрийн албанд орох нөөц 3739 иргэнээр нэмэгдэж, нийтдээ өнөөдрийн байдал төрийн албанд ажиллах нөөц 14000 байгаа юм.

Хувийн хэвилийнхэн ч төрийн албаны ерөнхий шалгалтын сонгон шалгаруулалтын нөөцийг судалж, боловсон хүчний нөөцөө судлах байдлын эхлэлүүд ч тавигдаж байна. Төрийн захиргааны албан тушаалын 729,

гүйцэтгэх албан тушаалын 5042, төрийн үйлчилгээний байгууллагын төсвийн шууд захирагчийн 358 албан тушаалын сул орон тоог нөхөх тусгай шалгалтыг зохион байгуулсан. Ингээд 3731 иргэнийг нэр дэвшүүлж томилуулсан болно.

Сонгон шалгаруулалттай холбоотойгоор Авлигын эсрэг НҮБ-ын конвенцын хэрэгжилтэд үнэлгээ хийсэн олон улсын шинжээчдийн тайланд төрийн албанд нэр дэвшигчийг сонгон шалгаруулах үйл ажиллагаа бүрэн цахимжсан нь сайн туршлага болсныг онцлон тэмдэглэсэн нь эерэг үзүүлэлт гэж үзэж байна.

3. Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил аажмаар буурах хандлагатай байна. Тайлант хугацаанд 415 төрийн албан хаагч ёс зүйн зөрчил гаргаж, хариуцлага хүлээснээс төрийн захиргааны албан тушаалтан 221, төрийн үйлчилгээний албан тушаалтан 194 байна. Ёс зүйн зөрчлийн тоо өмнөх оноос буурсан нь сахилга хариуцлага, ёс зүйг сайжруулах талаар УИХ-ын бодлого чармайлт төрийн байгууллагаас хэрэгжүүлж байгаа соён гэгээрүүлэх болон нөлөөллийн олон талт үйл ажиллагаа нь төрийн албан хаагчдын харилцаа, хандлага, ёс зүй, соёлд тодорхой хэмжээний эерэг нөлөөлөл үзүүлэх эхлэлийн үр дүн гэж үзэж байгаа юм.

Улсын хэмжээнд 2022 оны жилийн эцсийн байдлаар төрийн 2961 байгууллагуудын дэргэд Ёс зүйн зөвлөл байгуулагдан ажиллаж байна. Гуравхан жилийн өмнө 500 л байгууллагатай байсан, Ёс зүйн зөвлөл. Ёс зүйн зөвлөлийн үйл ажиллагаа, зөрчлийн бүртгэл, соён гэгээрүүлэх, мэдээллийн цахим системийг нэвтрүүлж ашиглах зэрэг ажлуудыг хийж байна.

Зөрчлийг тухай бүрд нь илрүүлэх, хариуцлага тооцох, нийтэд мэдээлэх тогтолцоо төлөвшиж, нийгмийн хяналтад орох нөхцөл бүрдлээ. Олон

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 05-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

нийтээрээ хэлэлцэгдэж байгаа Төрийн албан хаагчийн ёс зүйн хууль батлагдсанаар энэ хуулийн чиглэлээр тодорхой өөрчлөлт гарна гэсэн хүлээлт байна. Төрийн албанд зүй бусаар орж ирсэн, томилогдсон зарим нэг цөөн иргэний ёс суртахуунгүй үйлдлийг нийтэд хамаатуулан, төрийн алба, шударга төрийн албан хаагчдын нэр хүндийг бууруулах зарим хандлага байгааг ч онцлон тэмдэглэхийг хүсэж байна.

4. Хууль тогтоомжийн хэрэгжилтэд хийсэн хяналт шалгалт үр дүнд хүрч байна. Хуульд заасан томилгооны хяналт шалгалтыг тайлант онд төрийн 58 байгууллагын 1012 албан хаагчийг хамруулан хийж, 193 албан хаагчийг Төрийн албаны тухай хууль тогтоомж зөрчиж томилогдсоныг тогтоон, зөрчил арилгах хугацаатай үүрэг даалгаврыг томилох эрх бүхий албан тушаалтан болон албан хаагчдад хүргүүлж хэрэгжилтийг ханган ажиглалаа.

Тогтоосон хугацаанд зөрчлийг арилгаагүй тохиолдолд ТАЗ тухайн шийдвэрийг шууд хүчингүй болгож 31 тогтоолыг гаргаад байна. Хэрэгжилтийг хангасан болно. Хууль хэрэгжиж эхэлснээс хойш нийтдээ 453 байгууллагын 7178 албан хаагчийн томилгоонд хяналт хийж, дэлгэц дээр харагдаж байна. 1489 зөрчилтэй томилгоог илрүүлж хуульд нийцүүлэх арга хэмжээг авлаа.

Томилгооны хяналт шалгалтаас гадна чадахуйн зарчмын хэрэгжилтэд хийх хүний нөөцийн аудитыг яам, агентлаг, орон нутгийн төрийн 57 байгууллагын 1585 албан хаагчийг хамруулан зохион байгууллаа. Аудит хүний нөөцийн аудитыг анх удаа хийсэн. Аудитын үр дүнгээр 11 дүгнэлт, 39 зөвлөмж, 8 тогтоол гаргаж, гүйцэтгэлд нь хяналт тавин ажиглаж, зөвлөж, тусалж байна.

Төрийн байгууллагын үйл ажиглагаанд хүний нөөцийн аудит хийх

үндэсний хүний нөөц бэлтгэгдэж аудитын шинэ төрөл хэвшиж тогтох үндэс суурь тавигдлаа. Төрийн бүх шатын байгууллагаас хүний нөөцийн аудит хийлгэх сонирхол их байна. Зөвлөн туслах үйлчилгээ авах захиалга ч их байна. ТАЗ-д давтамжтайгаар энэ зөвлөгөөг хүссэн ажлууд эхэллээ. Ингэснээр зөв эхлэл, зөв хандлагын бодит илэрхийлэл болж байна гэж үзэж байна.

5-д нь, төрд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх хуулийн заалт бодитой хэрэгжиж эхэллээ. Шударга, ил тод, хариуцлагатай төрийн албыг төлөвшүүлэх нэг механизм шийдвэр гаргагчдын төрд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, хяналт тавих шинэ хуулийн зохицуулалт билээ. Хуулийн энэ заалтын дагуу төрд хохирол учруулсан хууль бус шийдвэр гаргасан 27 албан тушаалтанд холбогдох 303 сая төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлэх шаардлага хүргүүлж, шаардлагын биелэлтийг хангаагүй 7 албан тушаалтанд холбогдох 107 сая төгрөгийн нэхэмжлэлийг шүүхэд гаргаж хэрэг хянан шийдвэрлэх үйл ажиглагаа үргэлжилж байна.

Иргэний хэргийн шүүхээр 17 хэрэг эцэслэн хянан шийдвэрлэгдэж, төрд учруулсан 145 сая төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлэх шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болж шийдвэр гүйцэтгэх ажиглагаа явагдаж байгаа. Эдгээр арга хэмжээний үр дүн, нөлөөгөөр албан хаагчийг хууль бусаар томилох, чөлөөлөх зөрчил мэдэгдэхүйц багасаж, эрх бүхий албан тушаалтнууд хууль зүйн мэдлэгээ дээшлүүлэх, хууль бус шийдвэрийн эрсдэлээс урьдчилан сэргийлж, хүний нөөцийн зөвлөгөө, тусламж авах эрэлт хэрэгцээ эрс нэмэгдэж, хууль засаглах, соёл төлөвших эерэг эхлэл тавигдаж байна.

Ковидын дараах төрийн алба. 6. товчхон танилцуулъя.

Дэлхий нийтийг хамарсан ковид 19 цар тахал нь шинэ хуулийн хэрэгжих

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 05-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

хугацаанд тохиосон томоохон сорилт байлаа. Энэ хугацаанд зөвлөлийн зүгээс төрийн байгууллага, албан хаагчдад хандаж онцгой дэглэмийн нөхцөлд ажил үйлчилгээгээ хэрхэн зохион байгуулах вэ чиглэлээр зөвлөмж, шийдвэрүүд гарган, мэргэжил арга зүйн зөвлөгөөгөөр хангаж ажилласан.

Төрийн төв болон тусгай чиг үүргийн байгууллагын төрийн жинхэнэ албан хаагчид, эрүүл мэндийн салбарын бүх бие бүрэлдэхүүн ачааны хүндийг үүрч, иргэддээ үйлчлэх үүргээ нэр төртэй гүйцэтгэснийг энд онцлон тэмдэглэхийг хүсэж байна.

Ковидын хууль хүчин төгөлдөр хэрэгжиж эхэлсэн хугацаанд төрийн албанд томилогдсон нийт 2808 иргэний томилгоонд өнгөрсөн онд хяналт хийж, зөрчлийг арилгуулах талаар анхаарал хандуулан ажиллаж байна. Энэ үйл ажиллагаанд ч ЗГ-аас хэрэгжүүлж байгаа суурь “шүүр” ажиллагаа бас түлхэц болж байгаа гэдгийг тэмдэглэе.

7. Төрийн албанд томилогдох эрх нь хасагдсан иргэдийн судалгаа мэдээллийн сантай боллоо. Авлига, албан тушаалын гэмт хэрэг үйлдсэн нь нотлогдож, шүүхийн шийтгэх тогтоолоор нийтийн албанд томилогдох эрх нь хасагдсан иргэдийг хүний нөөцийн удирдлагын мэдээллийн цахим системд бүртгэн хяналт тавих ажлыг эхлүүлсэн. 2019-өөс 22 онд Шүүхийн шийтгэх тогтоолоор нийтийн албанд томилогдох эрх нь хасагдсан нийт 579 иргэнийг санд бүртгээд, 227 нь Эрүүгийн хуульд заасан авлига албан тушаалын гэмт хэрэг үйлдэж гэм буруутай нь тогтоогдсон тул эдгээрийг төрийн албанаас чөлөөлүүлэх хуулийн заалтыг хэрэгжүүлж ажилласан болно. Ингэснээр төрийн албанд шуударга, ёсны зарчим тогтох, авлига, ашиг сонирхлын зөрчлүүд ангид байх чиглэлээр нэг алхам хийгдлээ гэж үзэж байна. Ирээдүйд иргэд төрийн албанд итгэх итгэл, төрийн албан

хаагчдын нэр хүндийг сэргээхэд зохих нөлөө үзүүлнэ гэж үзэж байгаа болно.

8. Төрийн бүтээмжийг дээшлүүлэх, цахимжуулах ажил үр дүнгээ өгч байна. Төрийн ажил үйлчилгээг иргэдэд шууд хүргэх, хүлээлтийг багасгах, ил тод болгох, төрийн бүтээмжийг нэмэгдүүлэх нэг алхам нь цахимжилт байлаа. Энэ зорилгын хүрээнд ТАЗ хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоо, цахим системийг иж бүрэн хөгжүүлэх, мэдээллийн бусад суурь системүүдтэй интеграц хийх, мэдээллийн чанарыг сайжруулах, эх хөгжлийн сан бүрдүүлэх холбогдох байгууллагуудыг мэдээллээр хангах ажлыг гүйцэтгэсэн болно.

Хүний нөөцийн мэдээллийн тогтолцоо 12 модуль бүхий иж бүрэн цахим системийг хөгжүүлэх зорилт тавин ажилласан. 22 онд ажилтны цалин хөлс, ёс зүйн зөрчлийн хяналт, сонгон шалгаруулалтын томилгоо гэсэн 3 модулийг нэмж шинээр хөгжүүлэн хэрэгжүүлээд байна. Нийтдээ 8 модулийг бүрэн ашиглаж байгаа. Солонгос улсын хамтын ажиллагааны байгууллага Койкагийн санхүүжилтээр өчигдөр гэхэд төрийн жинхэнэ албан хаагчдын гүйцэтгэлийн удирдлагын тогтолцоог бэхжүүлэх нь төсөл 3 жилийн хугацаагаар эхлэх ажил эхлээд байгаа.

Цахим системийг нийгмийн даатгалын товчлолоор и-Монгол, хуулийн этгээдийн бүртгэл, иргэний бүртгэл, боловсролын мэдээллийн сан, төрийн байгууллагуудын цалингийн нэгдсэн систем зэрэг мэдээллийн сангуудтай холбож, хур системээр дамжуулан мэдээлэл солилцох, төрийн аль нэг байгууллагад байгаа мэдээллийг иргэн, хуулийн этгээдээс шаарддаг хүнд суртал гаргадаг, хүлээдэг байдалтай эвлэрэхгүй байгаа. Төрийн үйлчилгээг хүндрэлгүй, түргэн шуурхай хүргэх боломжийг нэмэгдүүлж, төрийн бүтээмжийг сайжруулахад цахимжилт хувь нэмрээ оруулаа.

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 05-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

9. Цаг хугацаа, орон зайнаас үл хамааран тасралтгүй сурч боловсрох нөхцөлийг бүрдүүлэх ажлын эхлэлд ахиц гарлаа. Төрийн албан хаагчийн тасралтгүй сургалт хөгжил нь шинэчлэлтийн нэгэн хөшүүрэг юм. Тайлант хугацаанд хуульд заасан төрийн албан хаагчдын мэргэшүүлэх багц сургалтыг 9320 төрийн албан хаагч хамрагдлаа. Сургалтад хамрагдсан албан хаагчдын тоо өмнөх хувиас 50%-аар өссөн болно. Тэргүүн түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 53, эрхэлсэн түшмэлийн багц сургалтад 282, ахлах түшмэлийн багц сургалтад 806, богино, дунд хугацааны сургалтад 8100 албан хаагчид хамрагдсан.

Ирэх онд Удирдлагын академи болон бусад боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллагуудтай хамтраад мэргэшүүлэх багц сургалтын хэлбэр, агуулгад үндсэн өөрчлөлт хийхээр зөвлөлдөж эхлүүлээд байгаа болно.

ТАЗ дангаараа 7 хоног бүрийн 4 дэх өдрийн 10 цагаас 7:4:10 вебинар сургалтыг зохион байгуулж хэвшсэн. Энэ сургалт 32 сэдвийн хүрээнд зөвхөн 1 жилийн хугацаанд давхардсан тоогоор 92000 хэрэглэгчтэйгээр төрийн бүх шатын байгууллагын 150000 гаруй албан хаагчид хамруулсан. Бас энэ дээр УИХ-ын гишүүд дэмжлэг үзүүлэн мэдээллээр хангаж ажиллаж байгаа болно.

Төрийн албан хаагчдын мэдлэг чадварыг дээшлүүлэх шинээр батлагдан гарсан хууль, тогтоомж, журам, дүрэм, ТАЗ-ийн бодлого шийдвэрийг таниулах зорилгоор 114 удаагийн сургалт семинарыг зохион байгуулж, 12000 төрийн албан хаагч хамрагдсан байна.

Соён гэгээрүүлэх болон нөлөөллийн зорилготой сургалт семинарын үр дүнд төрийн албан хаагчдын дундах харилцаа, хандлага, соёл, сэтгэлгээний чиглэлээр эерэг өөрчлөлтүүд гарлаа.

10. Судалгаанд суурилсан төрийн албаны шинэтгэл үргэлжилж байна. Онцлох ажлын сүүлийнх нь байгаа. Төрийн албатай холбоотой суурь болон хавсарга захиалгат судалгаануудыг 47 чиглэлээр төлөвлөж, судалгааны үр дүнд үндэслэн бодлого шийдвэрийг гаргахад анхааран ажиллаж байна. 47 судалгааны жагсаалтыг дэлгэц дээр харуулж байгаа.

Төрийн албаны чиглэлээр хийсэн судалгааны каталог үүсгэж тайланг цахим хуудаст байрлуулж, олон нийтийн хүртээл болголоо. Тайлант онд төрийн албан хаагчийн нийгмийн баталгааны хэрэгжилтийн талаар суурь судалгаа, төрийн захиргааны албан тушаалын ангилал зэрэглэлийн талаар, төрийн албанд хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрийн талаар, үр дүнгийн талаар, төрийн захиргааны албан хаагчдын үндсэн цалин, нэмэгдэл хөлс, гүйцэтгэлд суурилсан цалингийн тогтолцоог боловсронгуй болгох чиглэлээр захиалах судалгаануудыг хийж гүйцэтгүүлээ. Судалгааны үр дүнд ТАЗ-өөс гаргасан санал, зөвлөмжийн дагуу төрийн албан хаагчдын ангилал зэрэглэл, цалингийн сүлжээ, нэмэгдэл урамшуулал, нэмэгдэл хөлсний талаар УИХ, ЗГ-аас тодорхой шийдвэрүүдийг үе шаттай гарган ажиллаж байгаа болно.

Үйл ажиллагааныхаа онцлох хэсгээ өндөрлөөд, төрийн албаны хүний нөөцийн өнөөгийн байдал, бүрэлдэхүүн, хөдөлгөөний талаар товч мэдээлэл өгье.

УИХ-ын эрхэм гишүүд ээ, ТАЗ нь төрийн албан хаагчийн улсын нэгдсэн тоо бүртгэлийг хөтөлж, Улсын Их Хуралд мэдээллээр хангах чиг үүрэгтэй. Энэ үүргийнхээ дагуу тайлангийн 2 дугаар хэсэгт төрийн албан хаагчдын улсын нэгдсэн тоо бүртгэлийн талаар дэлгэрэнгүй тусгасан болно.

Монгол Улсын төрийн алба нь 2022 оны төсвийн жилд 4232 төрийн байгууллагад, байгууллагад 225000 албан хаагчтайгаар төрийн бодлого, зорилт,

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 05-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

чиг үүргийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг эхлүүлсэн. Төрийн ажил албан тушаал эрхэлж байгаа төрийн албан хаагчдын бүрэлдэхүүнийг авч үзвэл 1.7%-ийг төрийн улс төрийн албан тушаалтан, 9%-ийг төрийн захиргааны, 20%-ийг төрийн тусгай, 67.4%-ийг төрийн үйлчилгээний ангиллын албан хаагчид эзэлж байна. Нийт төрийн албан хаагчдын 64.6% нь эмэгтэй, 35.4% нь эрэгтэй байгаа юм. Төрийн албан хаагчдын тоо нийт дүнгээрээ жил бүхэн өсөж ирсэн тоон үзүүлэлттэй байна. Хүн амын тооны өсөлттэй шууд хамааралтай болох нь нийт хүн ам, төрийн албан хаагчдын эзлэх хувь сүүлийн 10 жилд тогтмол 5-6%-тай байгаагаас харж болно. Жил бүр нэмэгддэг нь манай орны хүн амын өсөлт, насны бүтцийн онцлогоор хамаарч боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээ хүртэгчдийн тоо өсөж байгаатай холбоотой болно. Энэ хандлага цаашид ч хэвээр үргэлжлэх төлөвтэй байна. Иймээс төрийн суурь үйлчилгээний салбарын албан хаагчдын эрх зүйн байдал, хөдөлмөрийн харилцаа, цалин хөлс, нийгмийн баталгааг тусгайлсан хуулиар зохицуулах боломж хувилбар байгаа юм.

УИХ, ЗГ төсвийн хэмнэлтийн зарчмыг хэрэгжүүлэх хүрээнд тодорхой арга хэмжээ авч, хууль батлан хэрэгжүүлснээр төрийн улс төрийн албан хаагчдын тоо анх удаа өмнөх оныхоос 10 орчим хувиар буурсан. Энэ бол зөв шийдэл байсан гэдэг шийдвэр гарсны дараах үйл явцаас харагдаж байгаа юм. Энэ жишгээр төрийн захиргаа болон тусгай албан хаагчдын тоог тодорхой хугацаанд нэмэгдүүлэхгүй байх эсэх нь улс төрийн шийдвэр бодлогын асуудал юм. Ийм замаар ДНБ-д эзлэх зардлыг өсгөхгүй байх, хэмнэх, хэмнэлтийг төрийн албан хаагчдын цалин хөлс, нийгмийн баталгаанд зориулах байдлаар төсөв санхүүгийн хязгаарлагдмал нөөц үеийг даван гарах бодлогын шийдэл хүлээгдэж байгаа юм.

Цаашидаа хүний нөөцийн бодлого стратегийг үндсээр нь өөрчилж албан хаагчдын тоог нэмэгдүүлэх биш ур чадвар, гүйцэтгэл өндөртэй, цогц чадамж бүхий иргэнийг сонгон шалгаруулж бүрдүүлэх, сургаж бэлтгэх, тогтвортой, суурьшилтай байлгах бодлогыг хэрэгцээ шаардлага байгаа юм.

Эрхэм гишүүд ээ, Төрийн албаны тухай хуулийн 74 дүгээр зүйлд заасан төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сайжруулах чиглэлээр цаашид авах арга хэмжээний санал, төрийн албан хаагчийн хууль тогтоомжийг боловсронгуй болгох санал, мэдлэг, ур чадвар, туршилагад суурилсан хараат бус, шударга, ил тод, хариуцлагатай төрийн албыг бэхжүүлэх, төрийн албан хаагчдын ажиллах нөхцөл баталгааны талаар цаашид арга хэмжээний саналыг та бүхэнд товч танилцуулъя.

Дэлгэрэнгүй ном бусад эх үүсвэрүүд дээр байгаа.

1. УИХ-ын түвшинд. Үндсэн хууль бусад хууль тогтоомжид алсын хараа 2 50 урт хугацааны хөгжлийн бодлоготой уялдуулан төрийн албаны шинэчлэлтийн суурь зарчмыг шинэчлэх, төрийн байгууллагуудын бүтэц, төрийн албаны ангилал, төрийн албан хаагчийн нийгмийн баталгааг боловсронгуй болгох стратегийн баримт бичгийг баталж мөрдүүлэх

2. Төрийн албаны ангиллыг өөрчлөх хүрээнд Монгол Улсын ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөр болон Алсын хараа 2050 бодлогын баримт бичигт туссан төрийн албан хаагчдын тоог үе шаттай зохистой түвшинд хүргэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх

ЗГ-ын түвшинд. 1 дэх санал. Төрийн албан хаагчдын үйл ажиллагааны гүйцэтгэлийн үнэлгээг боловсронгуй болгох, гүйцэтгэлд суурилсан үнэлгээ, цалин хөлс, урамшууллын тогтолцоог нэвтрүүлэх, ажлын үнэлэмж, эдийн

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 05-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

засгийн баталгаа, хариуцлагын тогтолцоог хамтад нь шийдвэрлэх, 360 хэмийн үнэлгээний систем нэвтрүүлэх одоогийн зарим дүрэм журмыг хялбаршуулах зэрэг асуудлуудыг тусгаад

2-т нь, нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенц, олон улсын хөдөлмөрийн байгууллагын 100 дугаар конвенцод зааснаар ижил үнэлэмжтэй ажилд адил цалин хөлс олгох үндсэн зарчимтай тул суурь цалингийн хэмжээ хэт зөрөөтэй байгааг арилгах замаар төрийн албан хаагчдын шилжилт хөдөлгөөнийг бууруулах, тогтвор суурьшилтай ажиллуулах, идэвх санаачилгатай ажиллах нөхцөлийг бүрдүүлэхээр байгаа юм.

УИХ-ын эрхэм гишүүд ээ, төрийн албаны төлөвшил, хөгжлийн өнөөгийн байдал, чадавхын зарчмын хэрэгжилт, төрийн албан хаагчдын сахилга хариуцлага, ёс зүй, төрийн албаны сургалт, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах чиглэлээр ТАЗ-өөс 2021, 22 онд хэрэгжүүлсэн үйл ажиллагааны товч тайланг танилцууллаа. Анхаарал хандуулсанд баярлалаа.

Н.Энхболд: Баатарзориг даргад баярлалаа.

Хуулиар ТАЗ-ийн жилийн ажлын тайланг хэлэлцэхэд Их Хурлын Тамгын газрын Хяналт шалгалт, үнэлгээний газраас бас дүгнэлт, саналууд оруулах ёстой. 21, 22 оны ийм дүгнэлт, саналууд ирсэн. Эдгээрийг нэгтгээд УИХ-ын Тамгын газрын Хяналт шалгалт, үнэлгээний газрын Хяналт шалгалтын хэлтсийн дарга Лхагвасүрэн танилцуулга хийнэ. 6 номерын микрофон өгье.

Ж.Лхагвасүрэн: Байнгын хороон дарга, эрхэм гишүүд ээ, Монгол УИХ-ын хяналт шалгалтын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.5 дахь заалт, Төрийн албаны тухай хуулийн 74 дүгээр зүйлийн 74.1 дэх хэсэгт заасны дагуу ТАЗ нь 2022

оны үйл ажиллагааны тайлангаа 2023 оны 3 дугаар сарын 31-ний өдөр УИХ-д ирүүлсэн.

Монгол УИХ-ын Тамгын газраас Монгол УИХ-ын хяналт шалгалтын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2 дахь хэсэг, Монгол УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 112 дугаар зүйлийн 112.3 дахь хэсэгт заасны дагуу хууль тогтоомжоор хүлээсэн чиг үүрээ хэрэгжүүлсэн талаарх ТАЗ-ийн 2022 оны тайланд шинжилгээ хийсэн болно.

Тайланд шинжилгээ хийхдээ Төрийн албаны тухай хууль тогтоомж, ТАЗ-ийн 2022 оны үйл ажиллагааны тайлан, ажиглалт, ТББ-аар гүйцэтгүүлсэн ТАЗ-ийн 2022 оны үйл ажиллагаанд хийсэн үнэлгээний тайлан болон 2022 оны Монгол Улсын төрийн албан хаагчийн улсын нэгдсэн тоо бүртгэлийн тайлан зэрэгт тулгуурлан баримт бичгийн болон статистик шинжилгээний арга зүйг ашиглалаа.

ТАЗ нь Төрийн албаны тухай хуулийн 66 дугаар зүйл болон Монгол УИХ-ын 2019 оны 17 дугаар тогтоолоор баталсан ТАЗ-ийн үйл ажиллагааны дүрмийн 2-т заасан бүрэн эрхээ 2022 онд хэрхэн хэрэгжүүлж ажилласан талаар, Төрийн албаны тухай хуулийн 74 дүгээр зүйлийн 74.1.1-74.1.4 дэх хэсэгт заасан агуулгын хүрээнд шинжилгээ хийж танилцуулгыг бэлтгэсэн болно.

ТАЗ-ийн 2022 оны үйл ажиллагаанд шинжилгээ хийгээд дараах үр дүнд хүрсэн байна гэж үзэж байна.

ТАЗ нь төрийн албанд ур чадварын шилжилт хийх, төрийн бүтээмжийг нэмэгдүүлэх, төрийн албан тушаалын ангилал хооронд ур чадварын шилжилт хийх талаарх эрх зүйн орчныг боловсронгуй болгох, холбогдох дүрэм, журмыг баталснаар төрийн албаны ангилал хооронд сэлгэх, шилжүүлэх, ажилтны ур чадварыг ашиглах замаар

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 05-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

хүний нөөцийн нөхөн хангалтыг тэлэх боломжийг бүрдүүлэн ажилласан байна.

ТАЗ нь “чадахуйн зарчмын хэрэгжилт” сэдвээр хүний нөөцийн аудитыг төрийн захиргааны байгууллага, албан хаагчийн 2019-2021 оны үйл ажиллагаанд хийсэн байна. Төрийн албан хаагчдын эрх зөрчигдсөн маргааныг хянан шийдвэрлэх үйл ажиллагааны хүрээнд төрийн жинхэнэ албан хаагчийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр ахиц гарч төрийн жинхэнэ албан хаагчийг сонгон шалгаруулах томилох үйл ажиллагаанд хяналт шалгалтыг тогтмол хийсэн байна.

Төрийн албаны хүний нөөцийн аудит жендерийн үзүүлэлт болон хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоо цахим системд төрийн албаны сахилга хариуцлагыг сайжруулах ажлын хүрээнд авлига, албан тушаалын гэмт хэрэг үйлдсэн нь нотлогдож шүүхээр ял шийтгүүлсэн төрийн албан хаагч болон шүүхийн шийтгэх тогтоолоор нийтийн албанд томилогдох эрх хасах ялаар шийтгүүлсэн талаар хар жагсаалттай болсон байна.

Хувь хүний зан төлөв хандлагыг тодорхойлох замаар шилжэж сонгох арга туршлагыг нэвтрүүлэх чиглэлээр төрийн албаны сонгон шалгаруулалтад сэтгэл зүйн тест ашиглан хувь хүний ёс зүй, зан төлөв, харилцаа хандлагыг тодорхойлох арга аргачлалыг туршин нэвтрүүлж эхэлсэн байна.

Олон улсын жишиг болон ярилцлагын Стар аргыг Монгол Улсад нэвтрүүлэх ажлыг эхлүүлсэн байна. Монгол Улсын ЗГ-ын 2022 оны 487 дугаар тогтоолоор төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, түүнд хамаарах албан тушаалын жагсаалтаар төрийн захиргааны албан тушаалын ангилал зэрэглэл 15 шатлалтай байсныг 10 болгосон байна.

УИХ-ын Тамгын газраас хийсэн шинжилгээний үр дүнд тулгуурлан Төрийн албаны тухай хууль тогтоомжийн хэрэгжилт түүний үр дүнг дээшлүүлэх үйл ажиллагааны эрсдэлийг бууруулахад чиглэсэн дараах зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд:

Нэгдүгээрт нь, ТАЗ-өөс төрийн албан хаагчийн ёс зүй, харилцаа хандлага, ажлын байранд баримтлах соёлыг төлөвшүүлэн хэвшүүлэх чиглэлээр соён гэгээрүүлэх сургалт, сурталчилгаа, хэлэлцүүлгийг тогтмол зохион байгуулж байгаа хэдий ч цаашид төрийн албаны шинэчлэлийг эрчимжүүлэхэд чиглэсэн үр дүнд суурилсан судалгаа шинжилгээ хийж үйл ажиллагаандаа үнэлэлт, дүгнэлт өгөх,

Хоёрдугаарт нь, төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийг хуульд заасны дагуу боловсруулж хэрэгжүүлэх үүрэгтэй ч хөтөлбөрүүдийн агуулга, хамрах хүрээ, хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлтийг боловсруулсан байдал харилцан адилгүй байгаад анхаарах,

3. Орон нутагт төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний чухал шаардлагатай мэргэжлийн зарим албан тушаалд ажиллах хүний нөөцийн хомсдол үүсэж албан тушаалын сул орон тоо нөхөгдөхгүй байсаар байгаад анхаарч энэ талаарх судалгаа шинжилгээ хийх, мэргэжлийн хүний нөөцийг бэлтгэх, оновчтой бүтцийг тогтоох ажлыг үе шаттай эхлүүлж зохион байгуулах,

4. зөвлөл нь Төрийн албаны тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1.8-д заасан төрийн албаны шинэчлэлийн бодлого, стратеги, хүний нөөцийн бодлогын хэрэгжилтийн явц, үр дүнд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, түүний үр дүнг дээшлүүлэх талаар санал зөвлөмж боловсруулах чиг үүргийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээг эрчимжүүлэн ажиллах,

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 05-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

5. Төрийн албан хаагчдын тоо жилээс жилд нэмэгдэж байгаа. Ялангуяа 2022 онд төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид 4.2-10.6%-аар өссөн хэдий ч үр дүн бүтээмж нэмэгдсэн талаар тайланд тодорхой дурдаагүй бөгөөд цаашид төрийн албыг цомхон чадварлаг болгох замаар цалинг нь нэмэгдүүлж, бүтээмжийг өсгөх, үр дүнг нь сайжруулах цогц шинэчлэлийг хийх,

6. 2019-2022 онд шүүхийн шийтгэх тогтоолоор нийтийн албанд томилогдох эрх нь хасагдсан нийт 579 этгээд мэдээллийн санд бүртгэснээс 227 буюу 39.2% нь Эрүүгийн хуульд заасан авлига, албан тушаалын гэмт хэрэг үйлдэж гэм буруутай нь тогтоогдсон байгаад анхаарч, цаашид төрийн албаны ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх зарчмыг баримтлан хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгоход анхаарах,

7. Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлийн тоон үзүүлэлт 2021 оноос 0.1%-аар буурсан хэдий ч албан үүргээ гүйцэтгэх явцаа харилцаа хандлагын зөрчил олонтоо гаргаж энэ нь нийт зөрчлийн 75%-ийг эзэлж байгаад үнэлэлт өгч, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахиулахтай холбогдсон үр дүнтэй арга зүйн удирдлагаар хангах,

8. ТАЗ нь 2022 онд 2400 орчим байгууллагын дэргэд Ёс зүйн зөвлөл ажиллахаар төлөвлөсөн боловч 567 байгууллага буюу 23.6% нь өөрийн санаачилгаар Ёс зүйн зөвлөлийг байгуулан ажиллуулсан нь төлөвлөсөн зорилтын хэрэгжилт хангалтгүй байгаад анхааран ажиллах шаардлагатай байна.

Танилцуулж дууслаа. Анхаарлаа хандуулсанд баярлалаа.

Н.Энхболд: Баярлалаа. ТАЗ-ийн 21, 22 оны үйл ажиллагааны тайлан түүнд хийсэн шинжилгээний талаар ТАЗ-ийн дарга Баатарзориг, Их хурлын Тамгын газрын Хяналт шалгалт үнэлгээний газрын Хяналт шалгалтын

хэлтсийн дарга Лхагвасүрэн нарын тайланг сонслоо.

Дэгийн дагуу гишүүд дээрх 2 тайлан, дүгнэлттэй холбогдуулаад асуулт тавина. Нэрсээ өгцгөө. Адьясүрэн гишүүнээр тасаллаа. Оюунчимэг гишүүн асууя. Оюунчимэг гишүүний микрофоныг өгөөрэй.

М.Оюунчимэг: Өглөөний мэнд хүргэе. Манай ТАЗ тайлангаа маш сайхан ном 21, 22 гээд их дэлгэрэнгүй гаргасан байна. 21 он, 22 онтой харьцуулж манай УИХ-ын Тамгын газар дүн шинжилгээг ч их бас гайгүй сайн хийснийг юуны өмнө тэмдэглэе.

Тэгээд манай Монгол Улсын хувьд бид нар ярьдаг шүү дээ. Төрийн алба хүчтэй байх ёстой, чадварлаг байх ёстой, мэдээж тэгээд цомтой байх ёстой гэдэг. Сүүлийн нэг хэдэн жилүүдэд төрийн алба данхайсан, төрийн алба дэндүү ингээд цунх баригчдаар дүүрсэн гэдэг ойлголт хавтгай явсан нь өөрөө эргээд төрийн албыг маш их сул болгоход хүргэж байна гэсэн дүгнэлтийг сүүлийн үед бас хийж байна л даа. Тэгээд энэ дүгнэлтээ та нар бас энэ ТАЗ санал нийлэх үү? 1 дүгээрт.

2-т, сая манай дүгнэлт дээр гарч байна. Бүтээмжийг нэмэгдүүлж цалин хөлсийг нь нэмэгдүүлж ингэснээрээ нөгөө чадварлаг хүчтэй төрийн алба байх ёстой. Гэтэл энэ тал дээр ТАЗ юу хийв? 1 дүгээрт энэ асуулт.

2-т нь, энэ 22 онд нийт 415 албан хаагч ёс зүйн зөрчил гаргасан гэж байна. Энэ нь 21 онтой харьцуулахад 0.1%-аар буурсан гээд. Тэгснээ энэ 0.1%-аар буурснаа та бүхэн маань албан хаагчдын харилцаа хандлага ёс зүйд соёлтой болгох сургалт семинар амжилттай хийсний үр дүн гэж харж байна гэж их том дүгнэсэн байна л даа. Минийхээр энэ дэндүү хангалтгүй бараг зөрчил гараагүй. Харин ч энэ дор нь харахад 21 онд нийт зөрчлийн 48, 9%-ийг албан байрандаа архидан согтуурах буюу 2-т нь төрийн албан

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 05-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

хаагчийн харилцаа ёс зүйн хандлагын зөрчил гэж гаргаж байсан бол 22 онд нийт зөрчлийн 75% нь харин энэ ажлын байрандаа архидан согтуурах 1-д, 2-т нь төрийн албан хаагчийн харилцаа хандлагын зөрчил эзэлж байна гэсэн байна. Өөрөөр хэлбэл энэ хамгийн ноцтой 2 зөрчлийн хувь хэмжээ 21 онтой харьцуулахад нэмэгдсэн байна. Тэгээд үүний шалтгаан юу вэ, яагаад энэ зөрчил ингэж нэмэгдэхэд хүрэв гэдэг дээр тодорхой хариулт өгөөч.

Сая та бүхэн маань хэлж байна. Сургалт, соён гэгээрүүлэх ажиллагааг бид нэлээд сайн явж байгаа 7:4:11 гээд тогтмол хийдэг боллоо энэ тэр гээд. 1 талаасаа энэ тогтмол хийдэг болж байгаа нь сайн хэрэг, харин та та нар маань дэндүү энэ сургалт, уулзалт, хурал, семинар Монголд бүр хавтгайрч байна. Би дүүрэг хороон дээр очиход 7 хоногт нээрээ өмнөх сая 1 завсарлагааны үед бараг 7 хоногт 3, 4 удаа очно, ТАЗ-ийн 1 сургалттай гээд бүгдийг хүчээр албаар суу гэсэн гээд хороон дээр байж байгаа нөгөө удирдах албан тушаалтнууд нь байхгүй, дүүрэг дээр хүн байхгүй. Бүр 7 хоног 3 очиход тийм юм болсон шүү дээ. Тэгээд би 1 удаа бүр Баатарзориг дарга руу утасдаад яасан их сургалт семинар хийдэг юм бэ наад хорооны хүмүүсийг ажил дээр нь байлгаач ээ гээд тан руу хүртэл ярьж байсан л даа. Энэ сургалт семинараа ч гэсэн жсоохон багасгаад харин ажлын байран дээрээ энэ хүмүүс сайн ажиллаж байна уу, үгүй байна уу, ажлын үр дүн нь байна уу, үгүй юу, үр дүн нь сайн байвал харин энэ хүмүүсээ яаж Монголын төр гүйцэтгэлээр нь, үр дүнгээр нь цалин хөлсийг нь нэмж энэ хүмүүсээ урамшуулж илүү тогтвор суурьшилтай сайн ажиллуулах вэ гэдэг дээр энэ зөвлөмжөөс би жишээ нь нэг их, яг тодорхой юм олж харахгүй байна л даа. Тэгээд энэ дээр 1 тодорхой хариулт өгөөч ээ гэж хүсэх байна.

3 дахь нэг асуулт маань одоо энэ хүйсийн тэнцвэрийн байдлын талаар маш сайн судалгаа энэ ТАЗ-ийн 22, 21 оны

тайлан дээр байна. Ингээд л харахад төрийн захиргааны албан дахь жендерийн баланс, гүйцэтгэх үйлчилгээ 2 дээр бүүр дэндүү алдагдсан байна л даа. Зарим газар нь бүр эрэгтэй хүйсийн хувь хэмжээ маш бага байна, зарим дээр нь эмэгтэй хүйсийг бүр 65 болоод ингээд үнэхээр баланс алдагдсанаас болоод жишээлбэл боловсролын салбар, эрүүл мэндийн салбарт сөрөг үр дүн маш их гарч байна гээд бүх судалгаа болгоноор гарч байгаа. Тэгэхээр та бүхэн маань сонгон шалгаруулалт хийхдээ энэ тал дээр ТАЗ яаж анхаарч, яаж асуудалд хандав гэдэг дээр 1 хариулт авъя.

Сүүлийнх нь ТАЗ-ийн нөгөө даргын сонгон шалгаруулалтыг Ди парламент дээр 1 сар зарласан санагдаж байна. Ингэхэд 6 хүн сонгон шалгаруулалтад нэрээ өгсөн байсан. Яагаад одоо болтол энэ нээлттэй сонсгол энэ тэр хийгдэхгүй байгаа юм бол? Энэ хаанаасаа энэ асуудал ингэж удаад байгаа юм бол гэсэн асуултууд эхлээд ... /минут дуусав/

Н.Энхболд: Сүүлийн асуулт бараг Их Хуралтай холбоотой асуулт юм. Энэ эд нараас өөрөөс нь шалтгаалахгүй байгаа, хугацаа нь дууссан хүмүүсийн талаар ЗГ-аас УИХ-аас санал нь ирчихсэн байгаа. Бид нар нөгөө хэлэлцүүлэх товоо Байнгын хорооноос зарлачихсан байж байгаа. Тийм, энэ дээр л ийм хариулт өгчихье.

Бусад хариултууд нь, хэн байна? Баатарсайхан дарга 3 номер.

Д.Баатарсайхан: ТАЗ-ийн тайланг хэлэлцэж, асуулт асууж байгаа та бүхэнд талархаж байна. Оюунчимэг гишүүний асуултад хариулъя. Төрийн байгууллагууд нэмэгдэж бүтэц нэлээн нүсэр байгаа гэдэгтэй ТАЗ санал 1 байгаа. УИХ ч гэсэн харж байгаа байх. Өнөөдөр одоо хэдэн яамтай, хэдэн агентлагтай, түүний харьяанд ажиллаж байгаа төрийн захиргааны бусад байгууллагууд гээд нэртэй байгууллагууд нэлээн олноороо байгуулагдсан. Төрийн албан

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 05-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

хаагчийн тоо өсөж байгаа гэж ярьж байгаа нь 1 талдаа төрийн суурь үйлчилгээг үзүүлж байгаа эмнэлэг, сургууль бусад соёлын байгууллагууд хэдийгээр нэмэгдэж байгаа ч гэсэн төрийн захиргааны чиг үүргийг гүйцэтгэж байгаа бас зарим байгууллагуудын тоо нэмэгдэж байгаа. Энэ дээр ямар асуудал ТАЗ дээр тулгардаг вэ гэхээр төрийн байгууллагын бүтэц зохион байгуулалтыг байгуулахад санал авахад ТАЗ-өөс санал авдаг байсан энэ заалт ТАЗ-өөс эрхээс байхгүй болсон. Тийм учраас ТАЗ бол энэ дээр санал өгөх ийм боломжгүй болгож яваад байгаа юм гээд.

Төрийн бүтээмжийг сайжруулах чиглэлээр бид энэ ковидын өвчлөлийн үр ашиг гэх нь хаашаа юм. Бид нэлээн цахимжсан байгаа. Тэгээд сая та хэлж байна, энэ 7:4:10 яасан их сургалт явуулдаг юм бэ гэж. Бид орон нутгаас томилолтын зардал гаргуулахгүй хүн хүчийг ажлыг нь орхиулж энд авчралгүйгээр ажлын байран дээр нь цахим байдлаар нэлээн сургалт явуулаад сая тайлан дээр дурдсан. Нийтдээ давхардсан тоогоор 110 гаруй мянган албан хаагчийг оруулж сургаад байгаа. Үүгээрээ дан ганц төрийн албатай холбоотой биш, хууль тогтоомжийг сурталчлах, сахилга хариуцлага, ёс зүйг хамгаалах тэр чиглэлээр, дээрээс нь мэдээллийн аюулгүй байдал гэдэг юм уу энэ чиглэлийн сургалтуудыг бас нэлээн явуулдаг юм. Энэ дээрээ бол бид харин төрийн байгууллагууд энэ 7:4:10 сургалтад чинь байнга хамрагдаж байя гээд хүрээ нь өргөжсөөд байгаа. 1 ээлждээ 3000 хэрэглэгч ороод цаанаа зуу гаруй мянган хүн бас хамрагдаад орчихдог ийм бололцоо одоотой сургалтууд байгаа.

Сонгон шалгаруулалтын үед анхаарах 1 зүйл гээд сая жендерийн асуудлыг хөндлөө. Энэ нэлээн төвөгтэй ч гэдэг юм уу ийм асуудал байгаа юм. Төрийн байгууллагууд захиалга ирүүлэхээрээ манайх энэ ажлын байран дээр эрэгтэй хүн авна шүү, эмэгтэй хүн

авна шүү, жендерийн тэгш байдлыг хангуулна шүү гэдэггүй. Хүний эрх талаасаа нөгөө талаасаа нийтэд зарлан мэдээлчихдэг. Ингээд орж ирсэн хүмүүс дундаас онооны байдлаараа сонгон шалгаруулалтын үнэлгээгээрээ өндөр үнэлгээ авсан хүнийг л нэр дэвшүүлээд ингээд явуулж байгаа ийм зохицуулалттай явж байгаа.

Тодорхой тохиолдолд манайх жендерийн байдлыг хангах гээд энэ удаагийн сонгон шалгаруулалтаар хүйсийн тийм байдлыг харгалзаж үзээч ээ гээд ирвэл бас зар мэдээлэл дээрээ тавиад явах боломж бий. Гэхдээ нөгөө талдаа энэ хүний эрхийн асуудал гэдэг асуудал нэлээн яригддаг аа. Миний хариулт ийм байна. Баярлалаа.

Н.Энхболд: Оюунчимэг гишүүн тодруулъя. Микрофоныг нь өгөөрэй.

М.Оюунчимэг: Тэр сонгон шалгаруулалтын явцад хүйсийн асуудлыг хөндөж тавих нь 1 талаасаа яах вэ хүний эрх гэдэг ч энэ чинь улс орны хөгжилтэй холбоотой асуудал учраас та бүхэн маань зар тавихдаа эсвэл ТАЗ-өөс энэ дээр бас балансыг барих юм уу чадварлаг ийм дээр энэ илүү сонгон шалгаруулалт авна гэх мэт тийм зөвлөмж энэ тэр өгч байвал зүгээр байна. Жишээ нь бид нар Японд үүнийг судлаад явж байхад энэ шаардлагыг бас тавьдаг юм байна лээ шүү дээ. Өнөөдөр тэгээд яаж бас төрийн алба нь тийм эрүүл саруул явж байна. Тэгэхээр бид нар энэ дээр нэгэнт бодолцох ёстой болов уу гэж бодож байна.

Ажлын хэсэг өмнө танай байгууллага дээр очиж ажиллахад ТАЗ гэдэг уг нь маш чухал байгууллага гэхдээ шүдгүй арслан шиг л байгууллага ингээд л байж байна гэсэн. Сая та бас ТАЗ-ийн санал авдаг байсныг ч ингээд болиулчихсан гэж байна. Тэгэхээр тэгэхээр цаашдаа яах вэ? Үүнийг ямар хууль, эрх зүйн актаар зохицуулах вэ? Байх хэрэгтэй юм уу, байх хэрэггүй юм уу. Эсвэл яаж энэ байгууллагын өгсөн

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 05-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

зөвлөмж нь үйл ажил болдог тэгээд тэрний үр дүнд өөрчлөлт гардаг үр дүн үзэгддэг байх ёстой л доо. Төрийн албаны тухай хууль дээр ингэх үү? Энэ дээр ... /минут дуусав/

Н.Энхболд: Хэн нь хариулах вэ? 3 номер. Манай ажлын хэсгийнхэн хариулахдаа нэрээ хэлээрэй.

ТАЗ-ийн гишүүн Баатарсайхан байна. Жендертэй холбоотой асуудал дээр ахиад тодотгол өгье өө. ЗГ-ын гишүүдийн 15% нь энэ тайлант оны хугацаанд ТНБД, ЗГ-ын агентлагийн дарга нарын 8.6-13.3% нь, аймаг НЗДТГ-ын дарга, ИТХ-ын нарийн бичгийн даргын 21.7% нь эмэгтэйчүүд ажиллаж байгаа. Өөрөөр хэлбэл энэ удирдах түвшинд ийм байна гээд. Харин сумын иргэдийн Хурлын нарийн бичгийн дарга, ЗДТГ-ын дарга нарын хувьд 52.7%-ийг нь эмэгтэйчүүд эзлээд ингээд ажиллаж байгаа. Тэгэхээр бас зарим хэсэг дээрээ энэ жендерийн асуудал гайгүй байгаа.

Улс төрийн албан тушаалтнуудын дотор эмэгтэйчүүдийн эзлэх хувь 22 оны байдлаар авч үзсэн тайлан дээрээ бид байж байгаа сайд нараас 15% нь л байх ёстой шүү дээ ЗГ-ын гишүүд нарын. Тэгэхээр зэрэг 9.5% нь гэдэг юм уу, дэд сайд нарын 10 ... /минут дуусав/

Н.Энхболд: Микрофоныг нь 1 минут нэмчих, 3 номер.

Д.Баатарсайхан: Нийтдээ ингээд 11.4%-тай явж байгаа. Ер нь энэ жендерийн асуудал дээр ТАЗ бас ер нь сонгон шалгаруулалтынхаа үед бүртгэл дээр хэдийгээр орж ирдэг ч оноо, сонгон шалгаруулалтын үнэлгээнийхээ явцад бол нөхцөл байдал яг нэр дэвшүүлэх үед бас өөр болчихдог ийм талтай. Баярлалаа.

Н.Энхболд: Занданшатар дарга асууна, микрофон өгье.

Г.Занданшатар: Та бүхний өдрийн амгаланг айлтгая. ТАЗ энэ

ковидын дараах төрийн албыг бэхжүүлэх, сэргээх, ковидын хуулиар томилогдсон хүмүүсийг чөлөөлөх энэ төрийн албыг чадавхжуулах талаар идэвх санаачилгатай сайн ажиллаж байгаа. Сонгон шалгаруулалтыг цахимжуулсан, холбогдох хууль тогтоомжийг боловсронгуй болгох чиглэлээр санаачилгатай ажилласан гээд багагүй ахиц амжилт бий.

Гэхдээ энэ 225205 болж төрийн албан хаагчдын тоо өслөө. 2018 онд ОУВС-ийн шаардлага болон юугаар 180000 гаруй төрийн албан хаагчид байхад түүгээрээ царцаа, тэтгэвэрт гарч байгаа болон ажлаас чөлөөлөгдөж байгаа хүний оронд орон тоо авахгүй байвал энэ төрийн албыг данхайлгахгүй юм гэж байсан. Яах вэ, нэг 67.6 нь төрийн үйлчилгээний алба буюу 152 мянгахан ТҮ нэртэй байгаа боловч энэ дотроос яг хэд нь эмч багш байна аа? Төрийн захиргааны алба дотор ТҮ нэрээр төрийн албаны хуулийн шаардлагыг тойрч гарах ийм хандлага их болсон байна. Үүнийг юу гэж үзэж байна?

Хоёрдугаарт нь, 2400 гаруй ёс зүйн зөвлөл ажиллах ёстойгоос 567 онд ажиллаж байна гэж байна. Энэ яагаад энэ ёс зүйн зөвлөлүүд бүх байгууллагууд дээр 2400 байгууллага дээр жигдэрч ажиллахгүй байна. Үүний шалтгаан юу байна аа?

Гуравдугаарт, энэ төрийн албаны ёс зүйн тухай хуулийг ТАЗ хамтран боловсруулаад өргөн мэдүүлээд 2 жил гаруй хугацаа өнгөрлөө. Энэ хооронд ёс зүйн зөрчлөөс улбаатай гэмт хэрэг, авлига, хээл хахууль олон асуудлууд төрийн албан дээр даамжирлаа. Энэ хууль ер нь батлагдан гарахгүй байгаа шалтгааныг та бүхэн юу гэж үзэж байна аа?

Дөрөвдүгээрт, ер нь энэ ёс зүйг хуульчлах шаардлага энэ 90-ээд оноос хойш ёс зүйн хэм хэмжээ, хязгаар гэдэг юм байхгүй болоод хуучин ёс зүй ул болоод

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 05-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

социализм гэж тэр үеийн хэм хэмжээ бол буруу гэж үзээд ардчилал гэдгийг анархизм юу дуртайгаа хийж болно, эрх чөлөө бол бүх юмыг хийж болно, гэр бүлийн харилцаанд ч, төр нийгмийн харилцаанд ч, нийгмийн бүх харилцаанд юу дуртайгаа хийж болно гэсэн ийм мораль ёс зүйн хэм хэмжээгүй үйл явдал хавтгайрснаас энэ гэмт хэрэг, зөрчил төрийн албаны доройтол бүх юм үүнтэй холбогдож байгаа учраас ёс зүйн хэм хэмжээг хуульчилж I хэм хэмжээг хуульчилж тогтоохгүй бол хуучин ёс уламжлал ч тэр алдагдлаа. Ийм шаардлагаар тавигдсан. Тэгээд үүнтэй холбоотой ер нь ёс зүйн зөрчлийн хэмжээ ямар байна?

Ноднингийн тайлан дээр 92 архидан согтуурах зөрчил ажлын байран дээр архи согтууруулах ундаа хэрэглэсэн зөрчил гарсан байсан. Энэ жил ямар болов? 2018 онд энэ Төрийн ордон болон төрийн бүх байгууллагууд архи согтууруулах ундаа хэрэглэхийг хориглосон журам гаргаж мөрдүүлсэн. Төрийн ордонд үүнийг Занданшатарын хар хууль ч гэж нэрлэдэг болчихсон байсан. Гэтэл энэ Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийг УИХ-аас баталсан. Албан байран дээр архидан согтуурахыг бас зөрчлийн хэмжээнд хэргийн хэмжээнд авч үздэг болсон. Тэгээд үүний хэрэгжилт ямар байна аа?

Ёс зүйн зөвлөл дээр энэ хэчнээн ажлын байран дээр архидан согтуурсан зөрчил гарав. Энэ маань явж явж ингээд гэмт хэргийн уурхай уг үндэс шалтгаан болдог. Ямар гашиун хэргүүд болж байсныг та бүхэн мэдэж байгаа. Энэ дээр тавьж байгаа энэ ёс зүйн зөвлөлүүд чинь ажиллахгүй байгаа нь 567 зөвлөл ажиллахгүй байгаа нь үүнтэй холбоотой юу. Юу гэж бодож байна аа?

Энэ дүгнэлт хэсэг дээр энэ төрийн албаны хууль тогтоомжийг боловсронгуй болгох багц хуулиудыг ЗГ-ын түвшинд хийх шаардлагатай ажлуудыг тодорхой

дурджээ. Энэ ажлууд маань ер нь ямар шатанд ... /минут дуусав/

Н.Энхболд: Хэн хариулах вэ? 7 номер.

ТАЗ-ийн гишүүн Идэрчулуун Занданшатар даргын асуултад хариулъя. Одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Төрийн албаны тухай хуулиар Төрийн албаны тухай хуулийн 66.1.1-д хууль өөр хуульд өөрөөр заагаагүй бол төрийн албаны удирдах болон гүйцэтгэх албан хаагчид төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ сахиулахтай холбогдсон зөвлөгөө өгөх, арга зүйн удирдлагаар хангах ийм л чиг үүрэг хэрэгжүүлж байгаа юм. Үүний хүрээнд бид нар энэ ТАЗ-ийн хүний нөөцийн нэгдсэн сангийн төрийн албан хаагчтай холбоотой бүрэн мэдээлэл хамрах тухайд 12 модуль хөгжүүлсэн дээр миний эрхлэх ажлын хүрээнд энэ маргаан хянан шалгах ёс зүйн асуудал ордог учраас энэ ёс зүйн модулийг энэ дүнд нь оруулаад хөгжүүлчихье ээ гээд ингээд санаачилгаараа 13 дахь модуль болгоод хөгжүүлээд явж байгаа.

Ер нь яагаад энэ ёс зүйн зөрчил гараад байна вэ. Түрүүн ч асуултад явна лээ ингээд тоо нь ихсээд байдаг та нар сайн ажилласан гээд байна гэж. Тэгэхээр энэ тоо өсөж байгаа нь нэгдүгээрт, Ёс зүйн зөвлөлүүд байгуулагдсан тоо өссөнтэй холбоотой. Хоёрдугаарт, ер нь эхлээд учраа олохгүй байсан энэ ёс зүйн зөвлөлүүд бас тодорхой хэмжээнд ажиллаад эхэлж байгаатай холбоотой энэ тоо өссөн байгаа. Сая даргын асуултад бол энэ ёс зүйн зөрчил дотроо архидан согтуурах энэ зөрчлийн тоо ер нь ямархуу байна вэ гэж сонирхож байна. 22 оны хэмжээнд албан үүргээ гүйцэтгэж байхдаа юм уу, ажлын байран дээр архидсан энэ зөрчлийн тоо 153 байгаа юм. Өнгөрсөн онд 21 онд 419 ийм зөрчилтэй бид нар тулж ажилласан. Тэгэхээр энэ ер нь энэ төрийн албанд энэ сахилга, хариуцлага сайжрахгүй байгаа. Энэ зөрчил гараад байгаа чинь бид нарын энэ урдах жилүүдэд төрийн албанд хаалгаар

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 05-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

нь ордог, тооноор нь ордог, цонхоор нь ордог, цүнх баригчдыг оруулдаг үүнтэй бас холбоотой байна. Одоо ч бас төрийн албанд ерөөсөө тэр өөрийнхөө ивээлд байдаг хүндээ найдсан, тэр намын харьяалалд найдсан, итгэл үнэмшилдээ найдсан ийм хүмүүс байгаад байгаа юм. Тэгээд ер нь 4232 байгууллагын 2961 ёс зүйн зөвлөл өнөөдөр байгуулагдчихаад байгаа юм. Одоо энэ хүчин төгөлдөр мөрдөж байгаа дүрмээр ажиллаж байгаа. Тэгэхдээ энэ ёс зүйн төрийн албан хаагчийн ёс зүйн хууль батлагдаж мөрдөгдвөл энэ зохицуулалтууд хямгад ороод ингээд цаашаа явчихна гэсэн ийм ойлголттой байгаа.

Тэгээд ер нь ингээд зөрчлийг дотор нь ингээд ангилаад харахаар ажлын цаг барьдаггүй, гол нь харилцаа хандлагын зөрчил дийлэнх хувийг эзэлж байгаа юм. Тэгэхдээ ажлын цаг барьдаггүй, удирдлагаас өгсөн үүрэг даалгавар биелүүлдэггүй хүмүүс чинь нэлээн олон тоо эзлээд байгаа юм. Тэгэхээр ерөөсөө өөрийнхөө хүчээр, ухаандаа өөрийнхөө хүчээр, төрийн албанд ороогүй, хэн 1-ний гуйлтаар шахалтаар, хуучин үлдсэн улбаа яриагаар бол бодлогоор орсон энэ хүмүүс нь ингээд дотроо үймүүлээд, хийх ёстой юмаа хийдэггүй ийм юмнууд бас ажиглагдаад байгаа.

Ёс зүйн зөрчлийг багасгах, соён гэгээрүүлэх чиглэлээр бид нар нэлээд хүрээнд ажилласан. Түрүүн даргын тайланд дурдагдсан ... /минут дуусав/

Н.Энхболд: Занданшатар дарга тодруулъя, микрофоныг нь өгье.

Г.Занданшатар: Ер нь тэр сургалт, судалгааны ажил хийлгүй яах вэ. Тэр чинь харин ч бага байгаа. Ер нь дэлхийн бүх жишиг ажлын байрны давтан сургалт, мэргэшүүлэх сургалтуудыг байгаа явуулж байх ёстой. Харин ч энэ Удирдлагын академийг ТАЗ-ийн харьяалалд байх нь зүйтэй юм шиг байгаа юм. Үүнийг юу гэж бодож байна аа? Тэгэхээр дангаараа сургалт явуулаад

хөдөө хот явуулаад явуулаад байдаг тэгээд Удирдлагын Академи чинь улс төрийн сургууль шиг юм болж хувирлаа. Харин ТАЗ дээрээ харьяалагдаж байх ёстой юм биш үү. Үүнийг юу гэж бодож байна? 1,

2-т нь, тэр Лхагвасүрэн дарга хариулаарай. Сая 567 гээд хэлчихлээ шүү дээ, ёс зүйн зөвлөл. Тэгээд та 2-ын тоо зөрөөд байна. Сая Хүдэрчулуун дарга 2-ын. Энэ тооныхоо зөрөөг надад тайлбарлах хэрэгтэй. 2961 гэж сая Хүдэрчулуун дарга хэлсэн.

3 дугаарт, энэ төлөвлөсөн зорилтын хүрээнд энэ төрийн албанд намын харьяалал, ах дүү, хамаатан саднууд маягтай ингээж томилоод байна гэж. Үүнийг бүгдийг нь сонгон шалгаруулалтаар томилдог болгосон байгаа шүү дээ. Тэгээд энэ ... /минут дуусав/

Н.Энхболд: Занданшатар даргын микрофон дахиад 1 минут өгөөдөх өө.

Г.Занданшатар: Тэгээд сонгон шалгаруулалтаараа томилогдож байвал хэн чадалтай хүн томилогдож байвал хэн ч байж болно. Тэгэхгүй одоо бүр сүүлдээ үүнийг чинь ингээд Үндсэн хуультай ч зөрчилтэй байж болзошгүй нийтийн албанд тийм тийм хүн ажиллаж болохгүй, тийм тийм зээл авч болохгүй ч гэдэг юм уу. Ингээд ийм хуульчлах маягаар зохицуулах гээд байна. Эцсийн эцэст сонгон шалгаруулалт л зөв яваад л тэр мерит чадахуйн зарчим бүх юм нь төрийн албаны энэ суурь философи зарчим нь ингээд үүнийхээ дагуу энэ сонгон шалгаруулалт гэвэл яагаад тийм харьяаллаараа юм уу, ах дүүс, хамаатан садан хүмүүс томилогдоод байдаг юм. Энэ нь нөлөөлөөд байдаг юм уу, чадлаараа болдог юм уу? Үүнээс болоод яагаад төрийн албаны чадамж суларч байгаа юм уу. Тэгээд эцэст нь ингээд төрийн ганц 2 хүнээс болоод зарим 1 ар, өврийн хаалгаар томилогдсон улсуудаас болоод төрийн албан хаагчдыг бүхэлд нь харлуулах, УИХ-

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 05-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

ыг ч гэсэн ингэж бүхэлд нь харлуулах юм бол Монгол төрийн чадамжийг доройтуулж нэр хүндийг унагаж байна.

Төрийн албан хаагчид шударга ажиллаж байгаа дийлэнх олонх нь ингээд үүнээс болоод хэлмэгдэж муу нэртэй боллоо гэж гомдол санал маш их ирүүлж байна, УИХ-д. Тэгээд энэ талаар ТАЗ-ийн байр суурь ямар байна гэдгийг тодруулъя.

Н.Энхболд: Хамгийн сүүлийн асуултад Баатарзориг дарга хариулъя. Тэгээд бусад нь бэлдэж байгаад Идэрчулуун бэлдэж байгаарай. 4 номер. 3.

Занданишатар даргын асуултад хариулъя. ТАЗ-ийн гишүүн Баатарсайхан. Сургалтын байгууллага магадгүй Удирдлагын академи ТАЗ-ийн харьяанд байвал яасан юм бэ гээд энэ уг нь зүйтэй, Синганурт, Орост гээд. Оросын ТАЗ-ийн дэргэд Ракс гээд сургалтын академи нь байж байдаг. Бас ийм байхыг бид, өөрөөр хэлэх юм бол төрийн албан хаагчийн талаар авч байгаа, сургаж хөгжүүлэх, давтан сургах энэ асуудалтай холбоотой бодлогыг нь хэрэгжүүлдэг байгуулагатайгаа хамт байвал зүйтэй байх гэдэг ийм саналтай байдаг.

Хамаатан садан олноороо ажилладаг уу энд тэнд тэр ямар асуудалтай вэ гэхээр би өөрөө төрийн албан хаагчийн төлөөлөөр ТАЗ-ийн гишүүнээр ажилладаг. Тогтоосон хууль дүрэм журмын хүрээнд ил тод үнэнч шударгаар ингээд хууль дээдэлж ажиллаж л байгаа бол заавал хамаатан садан гэхгүйгээр явах ийм бололцоо нь байдаг. Тухайлах юм бол би сумын Тамгын газраар жишээ авч 1 зүйлийг та бүхэнд бас товчхон тайлбарлая гэж бодож байгаа. Сумын засаг дарга гээд 1 хүн очдог, эхнэр нь их эмчийн мэргэжилтэй сумын эмнэлгийн эрхлэгчээр ажиллах болдог, хүүхэд нь малын эмчээр төгсөөд очдог. Ингээд ажиллах гэхээр зэрэг сумын Засаг даргын хамаатан саднууд ажиллаад байна гэдэг асуудал гардаг. Тэгэхээр хуулиа дээдлээд, хуулиа

хэрэгжүүлээд, үнэнч шударга ингээд ажиллах юм бол тэнд заавал хамаарал бүхий гэж ойлгогдохгүйгээр ажиллаад байх бололцоотой гэж ойлгодог. Баярлалаа.

Н.Энхболд: Идэрчулуун гишүүн 7 номер.

Б.Идэрчулуун: Би сая яах вэ, ийм юунууд зөрчлүүд байгаа гээд хэлсэн юм. Тэгээд 21 онд жишээлбэл бид нар 5277 хүний томилгоог үзэхэд 1112 нь хууль бус томилгоотой байгаа. Төрийн албаны сонгон шалгаруулалтаар оруулахгүй томилдог, Төрийн албаны тухай хууль дээр тавьсан шаардлага шалгуур хүрэхгүй хүнийг томилдог. 2022 онд энэ яам агентлагаар нь ялгах юм бол жишээлбэл 5277 хүний энэ 1112 нь хууль бус томилгоо байгаа нь яаманд 33, агентлагт 112, орон нутагт 967, тэгээд удирдах гүйцэтгэхээр нь харах юм бол 238 удирдах, 874 гүйцэтгэх албан тушаалтан гээд. Одоо ч гэсэн энэ жишээлбэл манай яамнууд дээр Байгаль орчны яам байна, ЭМЯ байна. Ерөөсөө хууль зөрчиж сонгон шалгаруулалтгүй томилоод байгаа энэ асуудал одоо ч үргэлжлээд байж байгаа. Аймгуудаас гэхэд Увс аймаг байна. Ерөөсөө ТАЗ-ийн шаардлагыг хүлээж авахгүй ингээд зөрчил гаргаад байгаа, нийслэл байна гэх мэт ийм юмнууд өөрөө байгаад байгаа юм. Тэгээд үүний ардаас бол бид нар хяналт шалгалтын ажил хийгээд дээр нь иргэд, төрийн байгууллага, албан хаагчдаас ирүүлсэн өргөдөл, гомдлоор энэ зөрчил, ийм дутагдал байна гэдэг ирснийх нь дагуу үүнийг шалгаж тогтоогоод тэгээд заримд нь хугацаатай үүрэг даалгавар өгч байгаа. Үүнийгээ биелүүлэхгүй тохиолдолд нь ТАЗ-ийн тогтоолоор хүчингүй болгож шийдвэрлэж байгаа юм, энэ томилгоог. Баярлалаа.

Н.Энхболд: Адьясүрэн гишүүн асууя.

А.Адьясүрэн: Ингээд та бүгдэд энэ өдрийн мэнд хүргэе. ТАЗ-ийн тайланг

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 05-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

сонслоо. Тэгээд үндсэн 3 асуудал дээр бас тайлбар авмаар байна. ТАЗ-ийн нэр хүнд иргэдийн дунд тааруу үнэлгээтэй байгаа гэдгийг бид нар бүгдээрээ мэдэж байгаа. Мэдээж бас олон шалтаг шалтгаан байдаг байх. Энэ дундаас иргэд хамгийн гол нь ТАЗ-ийг төрийн албан хаагчдынхаа эрхийг хамгаалдаггүй, зөвхөн шалгалт авдаг газар гэсэн ийм таагүй ойлголттой байдаг. Энэ дээр та бүгд бас ямархуу хэрхэн яаж ажиллаж байгаа юм? Энэ дээр бас би тайлбар авмаар байна.

2 дугаарт нь, энэ ТАЗ-ийн тайланд тэтгэвэртээ гарсан 5700 гаруй иргэн давхар ажиллаж байгаа талаар дурдсан байна. Гэтэл эдгээрийн дийлэнх буюу 5300 нь төрийн албаны төрийн үйлчилгээний албанд ажиллаж байгаа тухай бас дурджээ. Жишээлэх юм бол хөдөө орон нутагт сургууль, цэцэрлэг дээр зэрэг төрийн үйлчилгээнд ажиллах хүч дутагдалтай байгаа. Та нар бүгдээрээ мэдэж байгаа энэ талаар бас би тайлбарыг авах гэсэн юм.

Хамгийн сүүлд нь ЗГ “шүүр” ажиллагаа явуулж, энэ хүрээнд авах арга хэмжээний талаар хугацаатай чиглэл үүрэг даалгаврыг ЗГХЭГ-ын харьяа газрууддаа хүргүүлсэн байгаа. Энэ арга хэмжээний хүрээнд ТАЗ ямар үүрэг оролцоотой ажиллаж байна вэ? Мөн энэ арга хэмжээнд ЗГ-ын бус байгууллагууд тухайлах юм бол УИХ-аас байгуулагддаг албан газрууд хамрагдах уу?

Бас иргэд ярьж байна л даа. Энэ “шүүр” арга хэмжээний хүрээнд бага тушаалын хэдхэн хүнээр л хязгаарлаад эрх бүхий албан тушаалтнуудад хариуцлага тооцохгүй өнгөрчих юм биш биз дээ гэдэг бас ийм хүлээлт их байгаа. Энэ дээр та бүхэн ямархуу байр суурь баримталж байгаа талаар тайлбар авъя.

Н.Энхболд: Хэн хариулах вэ? 7 номер.

Гишүүний асуултад хариулья. ТАЗ-ийн гишүүн Амартөгс байна. ТАЗ-д эрхээ

сэргээлгэж хандсан төрийн албан хаагчдын 191 маргаан үүсгэж, комисс томилж хянасан байгаа. Тэгээд эндээс 79 шийдвэрийг буюу төрийн албан хаагчийн эрхийг хангаж шийдвэрлэсэн шийдвэрийг гаргаад, хэрэгжүүлээд, түүнд хэрэгжилтэд хяналт тавиад ажиллаж байна. Түрүүн өмнө нь асуусан асуултад бас 1 тодруулга мэдээлэл өгье гэж бод бодож байна. Энд төрийн албаны тоо хэмжээ харьцангуй их болоод байна гэдэг. Энэ асуудал дээр бид нарт тодорхой судалгаа шинжилгээнүүдийг бас хийж, дүгнэлтүүдийг гаргаж байгаа. Тухайлбал харьцуулсан судалгаа хийгээд үзэхээр Монгол Улсын нийт төрийн албан хаагчдын 1 төрийн албан хаагчид ноогдох дундаж хэмжээ 15.9 буюу 1 төрийн албан хаагч 15.9 иргэнд үйлчлэх ийм дундаж тоо байна. Үйлчилж байгаа гэсэн дундаж тоо байна. Үүнээс төрийн захиргааны албан хаагчид 156.7 гэсэн ийм үзүүлэлт нэгдсэн дүнгээр гараад байгаа. Тэгэхээр энд үндэслээд бид нар юуг хэлж байгаа вэ гэхээр энэ төрийн албаны ангиллыг илүү тодорхой болгоо, хэрэгжүүлж байгаа чиг үүргийн шинжилгээнүүдийг нарийвчилж онцлогтойгоор төрийн захиргааны шатлалын хүрээнд нь хийснээр үүнийг оновчтой тогтоож болно. 1 дүгээрт.

2 дугаарт, тооны хязгаар тавихаас илүү зардлын цалин хөлсний гэдэг юм уу, энэ зардлыг өсгөхгүй байх. Ингэхдээ гүйцэтгэлд суурилсан мөн үр дүнд чиглэсэн менежментийн түвшинд үр дүнд суурилсан цалин хөлсний тогтолцоог нэвтрүүлснээр хэмнэгдэж байгаа цалин хөлсний зардлаа нийт төрийн албан хаагчдын цалин хөлсний суурь түвшнийг нэмэгдүүлэхэд зарцуулах нь зүйтэй гэсэн ийм зүйл байгаа.

Цалин хөлсний бүтцийн өөрчлөлтийг хийх шаардлагатай гэж үзээд өгсөн саналыг нь ЗГ-ын ажлын хэсэгтэй хамтарч ажиллаад үе шаттай авч хэрэгжүүлэх арга хэмжээнүүдийг эхлүүлсэн. Энэ нь шаталсан буюу ангилал зэрэглэлийн тоог цөөрүүлэх, 5 шатлал бүхий цалинг 1 суурьд шилжүүлэх,

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 05-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

аажмаар нэмэгдэл, нэмэгдэл хөлсний ялгаа нь үр дүнтэй уялдсанаар илүү үр дүнтэй ажиллаж байгаа албан хаагчид илүү цалин авах гэсэн ийм зүйлийг хийнэ.

Ангилал зэрэглэлийг боловсронгуй болгох хүрээнд энэ төрийн албаны яг төрийн байгууллагууд юу хийх вэ, алсын хараа, чиг үүрэг нь юу байх вэ, байгууллагууд хэрхэн яаж оновчтой зохион байгуулагдаж байна вэ гэдэг дээр мөн судалгаа хийгээд анхан шатны судалгаа хийгээд үзэхэд төрийн захиргааны байгууллагуудаас эхлэхэд дунджаар 1 удирдах ажилтанд ноогдож байгаа албан хаагчийн тоо 5 орчим гарч байгаа юм. Яам агентлагийн түвшинд. Тэгэхээр бид энэ бүтцийн энэ агуулгууд дээр нь өөрчлөлт хийх замаар аль болох төрийн үйлчилгээг хүргэж байгаа шатандаа хүртээмжийг нэмэгдүүлэх, шаталсан бүтэц болон удирдах албан тушаалтнуудын цоог цөөрүүлэх гэсэн ийм бодлого баримталбал илүү үр дүнтэй болно гэсэн ийм судалгаа шинжилгээнүүдийг хийж байна.

Н.Энхболд: Тэр төрийн албан хаагчдын эрх ашгийг хамгаалдаг уу талаар. Тэтгэвэрт гарсан хүмүүсийн талаар.

Ц.Амартөгс: Саяын хяналт шалгалт хийгээд үзсэн юун дээр 80 хувьд нь бид төрийн албан хаагчийн эрх ашиг зөрчигдсөн гэж үзэж шийдвэрийг төрийн албан хаагчдын талд гаргаж байгаа.

Тэтгэвэрт гарсан энэ асуудлаар өнгөрсөн оны төсвийг дагаж гарсан хууль дээр төрийн жинхэнэ албанд тэтгэвэр тогтоолгосон хүмүүсийг ажиллуулахгүй байх ийм шийдвэр гарсан. Харин мэргэжлийн үйл ажиллагаа явуулж байгаа төрийн үйлчилгээний ... /минут дуусав/

Н.Энхболд: Баатарзориг дарга нэмэх үү? 4 номер.

Б.Баатарзориг: Их Хурлын даргын сүүлийн асуулт байгаа, энэ ёс зүйтэй холбоотой цөөн хүний зөрчлийг нийтэд хамаатуулах хэлбэрээр ийм шүүмжлэлүүд гарч байна. Үүнийг ТАЗ ямар байр суурьтай байна вэ гээд. Би товч илтгэл дээрээ дурдсан байгаа. Төрийн албанд зүй бусаар орж томилогдчихоод байгаа цөөн хэдэн хүний ёс суртахуунгүй үйлдлийг нийтэд хамаатуулаад төрийн албыг ч тэр дархлаагүй, шударга ажиллаж байгаа олон төрийн албан хаагчдыг нэр хүндийг бууруулах ийм хандлага бас давтамжтайгаар явагдах эрсдэлүүд байна. Энэ дээр бид нар анхаарал хандуулж ажиллаж байгаа болно.

2 дугаарт нь, сая хэлсэн төрийн албан хаагчдынхаа баталгааг хангахтай холбоотойгоор хэрхэн яаж ажиллаж байна вэ гээд. УИХ-аас томилогдсон ТАЗ-ийн гишүүдийн 2 нь төрийн албан хаагчдын эрх ашгийг хамгаалах чиглэлээр томилогдсон 2 байгаа. Манай Баатарсайхан дарга өөрийгөө сая илэрхийлсэн. Баатарсайхан дарга бол төрийн албан хаагчдын эрх ашгийг хамгаалах чиглэлээр төлөөлж байгаа. Дээр нь сонгон шалгаруулалтын асуудлыг хариуцаж байгаа. Амартөгс дарга бол сургалт судалгаа мэдээллийн сан дээр нь төрийн албан хаагчдын төлөөллийн асуудлыг хариуцаж байгаа. Олон өргөдөл гомдлууд ирдэг. Эдгээр өргөдөл гомдлуудын 80% нь төрийн албан хаагчдын талд шийдэгдэж байгаа, шийдвэрийн бүтцийнхээ хувьд ийм байгаа.

Тэтгэврийн тоотой холбоотой асуусан. Ингээд яг 22 оны 10 сарын 03-ны байдлаар нарийвчилж хэлбэл 5538 хүн тэтгэвэр тогтоолгоод ажиллаж байгаа юм. Үүний 5125 нь төрийн үйлчилгээний албан хаагчид байгаа. Эдгээр албан хаагчдыг бид нар бүр нэрээр нь эд нар судалж үзсэн, яахын аргагүй 330 сумд төрийн үйлчилгээний тогооч нь хүртэл олдохгүй байгаа. Нийслэлд зарим цэцэрлэгүүдэд, эмнэлгүүдэд эд нар гээд

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 05-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

ийм бэрхшээлийн үүднээс хүн хүчний хомсдолын үүднээс ийм дүн харагдаж байгаа юм. Үүнийг аль болохоор л бид нар хууль тогтоомжийн хүрээнд хүний нөөцийг бүрдүүлэх чиглэлээр ажиллаж байгаа. Бас уян хатан хандах ийм чиглэлүүд байгаа гэдгийг танд хэлье.

“Шүүр” ажиллагааны тухайд гагцхүү хуульд захирагдана, хууль дээдэлнэ гээд. Тэгээд УИХ-ын удирдлагууд ч гэсэн хууль бус үйлдэлтэй эвлэрэхгүй байх чиглэлээр ТАЗ-д шахалт шаардлагууд, санамж зөвлөмжүүд өгдөг өө. Энэ хүрээнд зөвхөн сүүлийн 14 хоногт гэхэд УИХ-ын харьяа УИХ-аас удирдлагад томилогддог байгууллагуудын хүний нөөцийн болон Тамгын газар, зарим удирдах ажилтнууд нийт 70 хамаарал бүхий төлөөллийг оролцуулсан сургалтууд зохион байгуулсан. Үүрэг, чиглэлүүд өгөгдсөн. “шүүр” ажиллагаа гүйцэтгэх засаглалын түвшинд хэрэгжиж байгаа асуудал биш ээ. Бүх түвшинд хэрэгжиж байгаа учраас эс үйлдэл хийх, зөрчлийг нуун дарагдуулах, хэрвээ хууль бус томилгоо үргэлжлүүлэх тохиолдолд 01 сарын 01-нээс хойших хууль бус томилгооны ишидвэр, төрд учирсан хохиролд тооцож явна гээд ийм нийтлэг шаардлагаар явж байгаа. Үүнийгээ ч ТНБД нар болон агентлагийн дарга нар, хүний нөөц, захиргааны удирд ... /минут дуусав/

Н.Энхболд: Адяасүрэн гишүүн тодруулъя.

А.Адяасүрэн: Гол юм нь энэ ТАЗ-ийг шалгалт авдаг, мөн тэгээд төрийнхөө албан хаагчдыг ёс зүйн хэм хэмжээ, маргааныг ишидвэрлэсэн л гэж байна. Гол юм нь энэ чинь төр өөрсдийнхөө албан хаагчдаа хамгаалах ёстой байх гэж би боддог. Хөдөө орон нутгаар уулзалт хийгээд явж байдаг, төрийн албан хаагчид маш бага цалин авдаг, төрийн албаа гүйцэтгээд явж байхад нь согтуу залуучууд ирээд зодчихоод яваад өгдөг, ийм тохиолдлууд зөндөө гарч байгаа. Дуудлагад явж байгаа эмч нарыг зодсон

тохиолдол Баянхонгор аймгийн Өлзийт сумд гарсан. Мал тооллогод явж байгаа төрийн албан хаагчдыг бас ингээд л зодоод танхайрчихдаг. Энэ дээр бид нар төрийнхөө албан хаагчдыг хамгаалах тал дээр ямар үйл ажиллагаа, ямар арга хэмжээ авах ёстой юм. Төрийн албан хаагчдыг хуулиараа хамгаалдаг болох ... /минут дуусав/

Н.Энхболд: 7 номер.

Тодруулгад хариу өгье. Амартөгс. Яалт ч үгүй энэ төрийн албан хаагчдыг хамгаалдаг систем гэдэг юм уу тогтолоо арга хэмжээ байх ёстой юу гэвэл байх ёстой гэдэгтэй тантай санал 1 байна. Энэ нь нөгөө 1 талаар төрийн албанд ороход төрийн албаны хуульд зааснаар маш олон хориглолт, хязгаарлалт тийм ээ, үүрэгжүүлсэн заалтууд хуулиар байдаг боловч хамгаалсан гэдэг юм уу зохицуулалт сул байна гэдэг ийм зүйлүүд судалгаан дээр гарч ирж байгаа юм. Тийм учраас нэгдүгээрт бид энэ хамгаалсан гэдэг юм уу үйл ажил ажиллагаагаа явуулах эрхийг нь хангах суурь нөхцөлийг нь бүрдүүлэх тал дээр эрх зүйн орчныг боловсронгуй болгох уялдааг нь хангах гэсэн энэ арга хэрэгслүүдийг нэгдүгээрт авч хэрэглэе. Энэ маань бас одоо яригдаж байгаа Төрийн албан хаагчийн ёс зүйн хууль дээр бас энэ зөрчил нь зөвхөн төрийн албан хаагчийг биш төрийн албаны үйл ажиллагаа болон үйлчилгээ авч байгаа хүмүүстэй холбоотой харилцаа зарим зүйлүүдийг тус ... /минут дуусав/

Н.Энхболд: 3 нэмээд хариулчих.

Адяасүрэн гишүүний асуултад хариулъя. ТАЗ-ийн гишүүн Баатарсайхан. ТАЗ-ийн хэрэгжүүлдэг чиг үүргийн нэлээн томоохон хэсэг нь энэ сонгон шалгаруулалт юм. Тэгэхээр шалгалт авдаг л гэж ойлгоод байх шиг байгаа юм. Өмнө нь байж байсан хуулийн зохицуулалтаас өнөөдөр ТАЗ нэлээн томоохон өөрчлөлтүүдэд орсон. Яг кноп дарчихсан юм юм шиг шууд шилжчих ийм

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 05-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

боломжгүй байгааг бас та бүхэн ойлгоорой. Тухайлах юм бол одоо албан тушаалын тодорхойлолтыг ажилд томилох гэж байгаа хүн нь өөрөө хүндээ тааруулаад баталдаг байсныг ТАЗ нэгтгэн хянаж, зөвшөөрөл олгодог болгосон. Энэ том амжилт болсон. Маргаан хянан шийдвэрлэх үйл ажиллагаа энэ шинэ хууль үйлчилж байж эхлэхээс өмнө жилдээ зургаахан маргаан шийддэг байсан бол одоо бид жилдээ 100 гаруй маргааныг шийдэж байна. Нэлээн олныг өргөдлөөр бас зохицуулаад явж байна. Ийм ажил нэмэгдсэн.

Дараагийн 1 ажил нь одоо юу нэмэгдсэн бэ гэхээр хүний нөөцийн аудит хийдэг болсон. Сая тайлан дээр гарсан байгаа. Өнгөрсөн хугацаанд бид ЭХЯ ... /минут дуусав/

Н.Энхболд: 1 удаа л тодруулах ёстой. Адьясүрэн гишүүндээ 1 минут өгчихье. Адьясүрэн гишүүний микрофон өгөөрэй.

А.Адьяасүрэн: Мэдээж ТАЗ тодорхой хэмжээний шаардлагуудыг тавиад шалгалтаа аваад ингэх нь зөв. Гол нь юу хүсээд байгаа юм бэ гэх дээр зэрэг энэ ТАЗ дарамт шахалт гэхээсээ илүү энэ төрийн албан хаагчдаа хамгаалаач ээ. Төрийн албанахаа энэ албан хаагчдынхаа бас цалин хөлсний асуудлыг бас хөндөх ёстой байна. Төрийн албан хаагчдаа хуулиар бид нар хамгаалж байж энэ хүмүүс чинь бас үйл ажиллагаагаа бас явуулах ёстой. Энэ дээр тодорхой хэмжээний хууль санаачилбал та бүхэн бас дэмжээд хамтарч оролцох уу?

Н.Энхболд: Яг би хэлье гэж бодож байсан юм. Түрүүн Адьяасүрэн гишүүний асуусан асуулт бол бас зөвхөн ТАЗ-тэй холбоогүй бусад эрх зүйн зохицуулалттай холбоотой. Энэ дотор, тухайлбал яг төрийн албан хаагчийн эрх эрх чөлөөнд халдсан бол тэрийг тусгайлан авч үзэх үү, үгүй юү гэдэг бодлогын асуудал байгаа юм. Түүнээс жишээ нь тооллогод явж байсан хүнийг

зодчихсон байгаа бол тэр эрүүгийн хэргээр шүүгдээд явах ёстой. Гэхдээ төрийн албан хаагч гэдгийнх нь хувьд бид нар энд онцгой бас одоо, жишээ нь цагдаа, хууль хэрэгжүүлэх байгууллагын ажилтнуудтай адилхан хэмжээний тийм юм байх уу, үгүй юү гэдэг бол эрх зүйн зохицуулалтынх нь асуудал. Тэгээд сая яг тэгж асуулаа. Ингээж ийм байдлаар асуудал тавивал та нар дэмжих үү гэж.

Хэн нь хариулах вэ? 3 номер.

Д.Баатарсайхан: Нэмэлтээр хариулъя. Нийгэм нэлээн бухимдалтай байна. Төрийн албан хаагч нарыг төрийн үйлчилгээг үзүүлэхдээ аль болохоор зөөлөн ур чадварын харилцаа хандлагаар иргэд олон нийттэй харьцаж байхыг бид зөвлөдөг. Сая Энхболд дарга ч хэллээ. Яалт ч үгүй эрүүгийн хэргийн шинжтэй байх юм бол тэрийг хууль хяналтын байгууллага тусад нь шийдээд явна.

Ер нь төрийн албан хаагчийн цалин хөлсний асуудал байгаа, бага боловч бас нэмэгдээд явж байгаа. Сум орон нутагт цалин хөлсийг нэмэгдүүлсэн, ангилал зэрэглэлийг бид одоо ТЗ-ийн 15 шатлалтай байсан ангилал зэрэглэлийг 10 болгоход бас өөрсдийн санал, судалгаан дээрээ суурилж өгсөн байгаа. Цалин хөлсөн дээр бол бид хэдийн тавьдаг гол асуудал бол түрүүн ч тайлан дээрээ дурдлаа. Ижил чиг үүргийг хэрэгжүүлж байгаа ажилтан, албан хаагчдад олон улсын хөдөлмөрийн байгууллагын нэгдэн орсон гэрээ конвенцын дагуу ижил цалин хөлсийг суурь цалинг нь ядахдаа ижил болгоод өгөөч ээ гэдэг дээр байнга санал хэлж байгаа.

Н.Энхболд: Адьяаа гишүүн.

Ш.Адьяаа: Өнөөдөр ТАЗ-ийн тайланг УИХ хэлэлцэж байна. ТАЗ бас сүүлийн жилүүдэд энэ төрөөс гаргасан хууль тогтоомж нэн ялангуяа төрийн албан хаагчидтай холбогдсон хуулийн хэрэгжилтийг хангах талаар бас санаачилга гаргаж ажиллаж байгаа гэж

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 05-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

ойлгож байгаа. Энэ бол сайн хэрэг. Гэхдээ өнөөдөр Монголын Төрийн албаны тухай хууль хэрэгжиж байна уу, хэрэгжихгүй байна уу, хуулийн өмнө тавигдсан шаардлага биелэгдэж байна уу, биелэгдэхгүй байна уу гэдэг дээр бид энд их шүүмжлэлтэй хандаж байгаа юм.

Өнөөдөр сая энэ төрийн албаны тайлан дээр ч ярилаа. Улс төрийн шахалтаар төрийн албыг томилдог энэ үйл ажиллагаа ямар түвшинд хүрснийг энэ судалгаа харуулж байна. Түүнчлэн өнөөдөр энэ УИХ болон хууль тогтоогчид сүүлийн үед энэ төрийн албаны ёс зүйн тухай асуудлыг босгож ирж, нийгэмд болсон нөхцөл байдалтай уялдуулж, бодит байдлын асуудлыг шийдэхгүйгээр ийм ёс зүйн асуудлыг ярьдаг. Ийм зүйл ярьсаар байгаад л бид энэ 3 жилийг өнөөдөр үдэж байна. Төрийн албаны ёс зүй ярих нь зөв. Гэхдээ тэр төрийн албанд ажиллаж байгаа төрийн албан хаагчдын нийгмийн баталгааны асуудлыг яах юм. Түүнчлэн өнөөдөр хэрэгжихгүй олон хууль тогтоомжоо яах юм, бид нар. Орон нутагт ажилладаг төрийн албан хаагчдын ажлын байрны тодорхойлолт дүгнэлтийн асуудал дээр энэ хууль тогтоох байгууллага ямар зарчим баримтлах юм бэ. Өнөөдөр хөдөө орон нутагт төрийн үйлчилгээний болон төрийн захиргааны байгууллагад байх ажилтан олдохгүй байна шүү дээ. Энэ дээр яах юм. Цаашиаад 1 ийм цэнзур тавьчхаад л үүгээрээ төрийн албыг бүрдүүлнэ гэдэг энэ асуудал чинь өнөөдөр амьдралд нийцэхгүй байна. Тэгэхээр энэ ТАЗ-өөс ганцхан зүйлийг би асууя.

Энэ хөдөө орон нутагт нэн ялангуяа алслагдсан бүс нутагт ажиллах төрийн үйлчилгээнүүд төрийн албан хаагчдын ажлын байран дээр тавих шаардлагын талаар өөр бодлого баримтлах ийм боломж байна уу? Ийм асуудлыг та нар өнөөдөр ЗГ болон УИХ дээр энэ асуудлыг тавьсан уу? Өнөөдөр энэ төрийн албаны хуульд энд өөрчлөлт оруулах талаар ямар санаачилга гаргах вэ? Бодит амьдрал дээр өнөөдөр хөдөө

орон нутагт төрийн албан хаагчдын нийгмийн асуудал, цалин хөлсний асуудал, ажлын байрны шаардлагын асуудал чинь өнөөдөр төрийн албыг хойш татах дампуурах нөхцөлд хүргээд байна шүү дээ. Энэ дээр Төрийн албаны зөвлөл ямар дүгнэлт хийж байна аа? Та нар өнөөдөр хяналт шалгалт үүрэг хэрэгжүүлэхээс гадна төрийн алба цаашид ажиллах нөхцөл бололцооны асуудал, бодлогын шийдлийг энэ төр засагт тавих ёстой ийм үүрэгтэй байгууллага гэж ойлгож байгаа учраас энэ дээр 1 хариулт авъя.

Н.Энхболд: Баатарзориг дарга хариулах нь зөв байх, 4 номерын микрофон өгье.

Б.Баатарзориг: Адьшаа гишүүн яг энэ уулзалт дээр биш бас зэм ч өгдөг, дэм ч өгдөг ийм гишүүн байгаа юм. Төрийн албаны шинэтгэлд бас санаа зовоод байдаг. Энэ орон нутгуудад боловсон хүчин дутагдалтай байдал дээр бид нар дүгнэлт хийгээд ингээд сонгон шалгаруулалтын 5 өөр өөр журам тусдаа журмуудыг унишилтад тэр, зохицуулах механизм ч тэр 1 байя гээд олон энэ 5 журмыг 1 журам болгоод ингээд зохицуулалтыг хийхдээ хөдөө орон нутагт хүний нөөц боловсон хүчин дутагдалтай үед мөн зарим салбарууд нь хүний нөөц бас орон нутгуудад дутагдалтай үед сонгон шалгаруулалтыг тухайн орон нутгийн захиалгаар зохион байгуулах. Гэхдээ тэр сонгон шалгаруулалт тухайн орон нутагтаа үйлчилнэ. Тэнд сонгон шалгаруулалт өгчхөөд яаманд илжж ирэх боломжгүй. Тэр хөдөөгийн сэргэлттэй холбоотойгоор тухайн орон нутгийн хүний нөөцийг хангахтай холбоотой шинэ зохицуулалт ороод ажиллаж байгаа. Жишээ нь Байгаль орчны чиглэлийн байцаагч нар улсын байцаагч нар гэхэд улсын хэмжээнд дутагдалтай, бас зарим хүндрэлүүд байдаг. ХАА, МАА эд нар гээд ийм зүйлүүд дээр журам дүрмүүдэд өөрчлөлт орсон.

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 05-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

Дараа нь дараагийн өөрчлөлт бол туслах түшмэл дээр сонгон шалгаруулалтын болон ажилласан жилийн эд нар босгууд байсан. Бас хөдөө орон нутагт хүний нөөцийг хангахтай холбоотойгоор туслах түшмэл, дэс түшмэлүүдэд тавигдах босгыг уян хатан болгосон байгаа. Энэ зүйлүүдийг хийсэн.

Мөн сонгон шалгаруулалтын багц журамтайгаа холбоотойгоор төрийн үйлчилгээний удирдах ажилтны сонгон шалгаруулалтын агуулга зарим зүйлүүдэд энэ харилцаа хандлагын чиглэлийн өөрчлөлтүүд бас тусгаад ингээд явж байгаа. Ийм зүйлүүдийн эхлэлүүд тавигдаад журам 4 сарын 1-нээс эхэлж мөрдөж байгаа юм. Энэ 4 сарын 1-нээс. Асуулт асуусан танд баярлалаа.

Н.Энхболд: Ойлголоо, баярлалаа. Тийм. Энэ ер нь төрийн албаны зүгээс үнэхээр орон нутгаас ирж байгаа саналуудад нөхцөл байдалд нь бас тааруулсан. Аль болохоор төрийн албан хаагчдыг их өндөр босго хэтэрхий хатуу шаардлагаар ажиллах боломжийг нь хаагаад байхгүй чиглэлээр бас тодорхой арга хэмжээнд авдаг юм байна лээ. Өөрсдийнхөө хэмжээнд шийдээд тэр ажлын байрны тодорхой шалгууруудыг нь бас үзэж байгаа нь тэр ерөнхийдөө зөв байр суурь юм уу гэж бодож байгаа. Ялангуяа өнөөдөр. Гэхдээ бид нар цаашидаа ер нь Монголын төр, хөдөө, хот гэлгүй зүгээр орон нутаг хэцүү байгаа учраас гээд бүх юмныхаа босгыг нь доошлуулаад байвал хэцүү шүү дээ. Бид нар чинь хэдэн жилийн өмнө ярьж байгаад зүгээр ер нь орон нутагт бас ажиллаж байгаа боловсон хүчин, заавал тэнд тодорхой шаардлага хангасан хүмүүс ажиллуулахгүй бол чанар нь муудаад байна гэдэг юм ярьж байгаад л тодорхой болзлууд тавьсан. Уян хатан байх юм нь бол байх л байх. Гэхдээ ерөнхий том хандлага маань бас төрийн албаа чанартай боловсролтой, мэдлэгтэй, мэдээлэлтэй шинэ үеийн хүмүүсээр дүүргэхэд юм болгон дээр тэрийг нь доош нь хийгээд хаяад байвал

бас тийм ч их зөв биш байх гэдэг дээр анхаарах байх гэж байна. Баярлалаа.

Гишүүд асуулт асуугаад, хариулт авч дууслаа. Одоо үг хэлэх хүн байна уу? Занданшатар даргаар, би дараа нь I товчхон үг хэлнэ. Занданшатар даргын.

Г.Занданшатар: Ер нь энэ ТАЗ-ийн үйл ажиллагаа хараат бус, төрийн алба бол мэдэхүй, чадахуйн зарчим дээр суурилсан, ингээд чадвартай, ёс, зүйтэй төрийн албаны ийм тогтолцоо Монгол Улсад байж байж Монгол төрийн нэр хүнд өндөр байна. Энэ талаар ТАЗ төрийн албаны тухай УИХ-ын баталсан хуулийг хэрэгжүүлж ажиллаж байгаа, зохих тодорхой үр дүнгүүд гарсан, сонгон шалгаруулалтыг цахимжуулж, хараат бусаар үр дүнтэй явуулж байгааг харж очиж үзсэн. Ийм сургалт судалгааны ажлуудыг эрчимжүүлж байна. Ер нь тодорхой ахиц дэвшилүүд байна.

Тэгэхдээ энэ хүлээлтэд хүрэхгүй байна нийгмийн хүлээлтэд хүрэхгүй байна. Одоо энэ бүх сонгон шалгаруулалтыг шударга, нээлттэй явуулдаг, хараат бусаар явуулдаг, энэ ярилцлагын үр дүнг хараат бусаар интернэтээр үзүүлж байгаад нээлттэй ярилцлагыг бас нээлттэй мод үр дүнтэй явуулдаг. Тэгээд энэ бүхний дүндээ тэр хувь хүний зан төлөвшил ёс суртахуун байдал бүгдээр нь үнэлэлт хийгээд төрийн албыг томилдог болчих юм бол энэ төрийн алба бас нэр хүнд нь өснө өө. Ийм учраас энэ төрийн өмчийн бүх компаниуд сая зөвхөн Эрдэнэс Монгол дээр хийлээ. Төрийн өмчийн бүх компанийн удирдлагуудыг сонгон шалгаруулалтаар томилдог байгаа. Ийм хууль журмыг гаргаж мөрдүүлэх хэрэгтэй. Төрийн бүх албан хаагчдыг сонгон шалгаруулж мөрдүүлдэг байх хэрэгтэй. Үүнийг зөрчиж томилогдсон бүх хүмүүсийг тэр “шүүр” ажиллагааны хүрээнд шүүрдэж цэвэрлэх хэрэгтэй. Энэ шаардлагыг авч хэлэлцэх хэрэгтэй. Энэ чинь төрийн бодлого зорилттой нийцэж байна шүү дээ.

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 05-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

Ийм учраас энэ тайланг УИХ-аар бас авч хэлэлцэж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх нь зүйтэй гэж үзэж байна. Ингээд ийм тодорхой чиглэл бодлого гарч байж, энэ төрийн албаны нэр хүндийг дээшлүүлэх, хараат бус, мэргэжлийн, чадахуйн зарчимд суурилсан, ёс зүйтэй, авлига хээл хахуульгүй, хүнд сурталгүй энэ төрийн албаны нэр хүндийг өсгөхөд УИХ онцгой анхаарах нь зүйтэй. ТАЗ ч гэсэн энэ дээрээ тодорхой ахиц шийдэл гаргаж ажиллах хэрэгтэй. Энэ сонгон шалгаруулалтаар сая Хүдэрчулуун даргын хэллээ. Тэр намын харьяалаар, ах дүүсийн зарчмаар нөлөөллийн дагуу томилогдож байгаа юмнуудыг бүгдийг нь таслан зогсоох хэрэгтэй. Үнэхээр чаддаг мэддэг байвал одоо хэнбугай нь ч байсан тэр төрийн албандаа ажилладаг ч юм уу ёс зүйтэй чадвартай хүн бол ажлаа хийсэн шиг хийдэг, авсан шиг авдаг болох хэрэгтэй.

2 дугаарт нь, төрийн албыг цомхон чадварлаг болгож, үүний үндсэн дээр төрийн албан хаагчдын нийгмийн баталгаа, цалин хангамжийг дээшлүүлэх хэрэгтэй. Энэ ковидын үед 30%-аар ажиллахад болоод л байсан. Тэгэхээр энэ ажлын үнэлэмж, бүтээмж, ажлын ачааллыг зөв үнэлж, энэ төрийн албан хаагчдын цалинг нэмэгдүүлэхгүй болбол тэгээд тэр авсныхаа хэмжээгээр цалин авдаг тогтолцоог эрүүл мэндийн салбарт хийснийхээ хэмжээгээр ажил авдаг энэ бүтээмжид суурилсан үр дүнд суурилсан цалингийн тогтолцоо нэвтрүүлэхэд тодорхой үр дүнгүүд гарч байна шүү дээ. Тэгэхээр бүх шатанд одоо үүнийг тэр Шинэзеландын туршилагыг нэвтрүүлсэн гээд байгаа тэр үр дүнд суурилсан цалин хувьсах зардлын тогтолцоогоо хэрэгжүүлж байж төрийн албаны төрийн албан хаагчдын нийгмийн баталгаа сайжирна. Авдаг цалин нь хэд байна. Мааш их хэл ам гарч байна. Сумд тэр дээрээ босоо удирдлагатай агентлагуудын албан хаагчдын цалин хамгийн том асуудал боллоо. Тав 600 мянган төгрөгийн цалинтай байхад ажил төстэй ижил үүрэг бага бараг ажил

хийж байгаа хүн бараг 2 дахин их цалин аваад байх жишээтэй. Тэгэхээр энэ цалингийн тэгш шударга байх, тэгээд хийсэн чадсанаараа үнэлэмжээрээ авдаг байх, энэ төрийн албаны цалин хангамжийн асуудлыг нэвтрүүлэхгүйгээр, нэмэгдүүлэхгүйгээр, шийдэхгүйгээр энэ төрийн алба чинь бас шударга ёс зүйтэй ажиллах бодит нөхцөл бодол хангагдахгүй. Ийм учраас төрийн албанд ийм цогц шинэчлэл хийх бодлогыг даацтай хийгээч ээ гэж шаардаж байгаа юм.

1 талдаа ёс зүй сахилга хариуцлага шаардаад байдаг. Нөгөө талдаа тэр цалин хөлс хангамжийн асуудал нь ингээд энэ цогцоор нь шийдэхгүй бол зарим яам агентлаг бол хэд дахин өндөр олон албан тушаал, орон тоотой болсон байна. Сүүлийн 10 жилд 10, 10 жилээр ингээд л далдаад өсөөд яваад байдаг. Төрийн албан хаагчдын тоо нь, чанар бүтээмж нь ямар байна, үр дүн нь ямар байна. Энэ төрийн өмчийн компаниудын орон тоо, цалин хангамжийн систем нь ямар байна, тэдэнд тавигдаж байгаа шаардлага, сонгон шалгаруулалт ямар байна. Үүнийгээ цогцоор нь хараад нэгмөсөн нийтийн албанд энэ чанар бүтээмж, үр дүн, сахилга хариуцлагыг 1 цогцоор нь шийдэх шаардлагатай байна. Шаардлагатай бол Төрийн албаны хуульдаа ч нэмэлт, өөрчлөлт оруулж болно. Ийм бодлогын шинэчлэл хийх асуудлыг өнөөдөр энэ ТАЗ тайланг оруулж ирж байгаа дээр УИХ анхаарч шийдэж хэлэлцэж шийдвэр гаргах хэрэгтэй.

Төрийн албан хаагчдын эрх ашгийг хамгаалах асуудал байна. Ажил үүргээ гүйцэтгэж байгаад хохирч байна, зодуулж байна, дээрэлхүүлж байна. Төрийн тусгай албан хаагч ... /минут дуусав/

Н.Энхболд: Занданшатар даргад 1 минут нэмээд өгчихье. Занданшатар даргын микрофоныг өгөөдөх өө.

Г.Занданшатар: Тэгээд төрийн тусгай албан хаагчдыг хар. Албан үүргээ

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 05-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

гүйцэтгэж явж байгаа төрийн тусгай албан хаагчдыг нь зодуулж байна, нүдүүлж байна. Сая бас манай гишүүд ч гэсэн хэлж байна. Төрийн албан хаагчдыг ингэж нүд үзүүлэж хардаг бас 1 хандлага нөгөө талдаа болж байна. Ажил үүргээ гүйцэтгэж явж байгаад эрүүл мэндээрээ хохирч байна. Энэ чинь бас ард түмнийхээ эрүүл энхийн болон аюулгүй байдлын манаанд зогсож байгаа улсууд шүү дээ. Тийм учраас энэ төрийн албаныхаа нэр хүндийг өсгөж өөр өөрийг нь цэвэршүүлж шинэ шатанд гарах талаар дорвитой өөрчлөлт шинэчлэлт хийхгүй бол төрийн улс төрийн албаас авхуулаад төрийн үйлчилгээний алба хүртэл энэ дээр зохистой өөрчлөлтүүд хийх хэрэгтэй байна. Түрүүний асуусан асуултад тодорхой бус чуулган дээр нэгдэж хариулах хэрэгтэй. ТУ яг 152000 болсны яг хэд нь эмч багш байгаа юм? Яг гарцаагүй үйлчилгээний ажилтан болсон юм. ТУ нэрээр тоо өсөөд байна уу. Ингээд үүнийг 1 дорвитой шийдэл УИХ ажлаа тайлагнадаг байгууллагын хувьд ЗГХЭГ-тай хамтраад энэ дээр 1 эрс шинэчлэлийг хийх шаардлагатай байна.

Н.Энхболд: Баярлалаа. Өнөөдөр ТББХ-оор ТАЗ-ийн 21, 22 оны ажлын тайлан түүнд өгсөн зөвлөмж үнэлгээний талаар хэлэлцлээ.

Гишүүд асууж, байр сууриа илэрхийллээ. Хуулийн зохицуулалтаар тайланг холбогдох Байнгын хороогоор хэлэлцээд шаардлагатай гэж үзвэл УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанаар бас хэлэлцэж болно гэж заасан байгаа. Их Хурлын дарга манай Байнгын хорооны гишүүн, ер нь чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлье ээ энэ дээрээ төрийн албанд тулгараад байгаа асуудлуудыг цогцоор нь авч ярих тал дээр анхаарал тавья гэж санал гаргалаа. Энэ нь зүйтэй гэж бодож байна. Тэгэхээр бид нар энэ өнөөдөр Байнгын хороогоор хэлэлцээд дуусаж байгаа биш чуулганы нэгдсэн хуралдаанаар бас энэ тайланг дүгнэлт, зөвлөмжүүдийнх нь хамт хэлэлцүүлнэ.

Төрийн албаны талаар янз бүрийн байр суурьтай байгаа хүмүүс данхайж байна, их том байна гэж. Бусад улс орнуудын төрийн албатай харьцуулаад үзэхэд ялангуяа энэ төрийн захиргааны албан хаагч тал дээр нь харьцуулаад үзэхэд манайх бусад орнуудаас учиргүй их данхайчихсан юм бол харьцангуй гайгүй байдаг судалгаагаар. Яг өнөөдрийн байдлаар гэхэд нийт төрийн албан хаагчдын 1.7%-ийг нь л улс төрийн улс төрийн албан хаагч нар эзэлж байна. Тусгай албан хаагчид 20, 21 орчим хувь байна. Захиргааны албан хаагч нэг 9.8, тэгээд бараг 68%-ийг нь үйлчилгээний албан хаагч нар эзэлж байгаа. Ингээд аваад үзвэл жишээ нь төрийн тусгай албан хаагч нар 1 талаараа бас л нийтийн албан хаагч нар хууль сахиулах талаар үйлчилгээ үзүүлж байгаа албан хаагч нар гэж үзнэ ээ гэж бодвол нийт төрийн албан хаагчдын бараг 80-аад хувь нь, 90 орчим хувь нь энэ 2 ангилалд багтаж байгаа юм. Тэгэхээр энэ дээр бид нар бас их зөв мэдээлэл өгч ажиллах ёстой юм байна лээ.

Дээр нь төрийн өмчийн оролцоотой ААН байгууллагуудын тоо байгаа. Энэ дээр харин бид нар ялангуяа бид нар Их Хурлын зүгээс онцгой анхаарал тавьж ажиллаж байгаа. Шинээр ийм компаниуд байгуулж болохгүй гэсэн шийдвэр гарсан. Одоо байгааг үр ашиг, бусад зүйлүүд, нийгмийн шаардлага эдийн засгийн шаардлагыг нь харгалзаад цөөрүүлэх, бууруулах энэ чиглэлээр явах ёстой. Гэхдээ ТАЗ-ийн зүгээс голчлон энэ улс төрийн, тусгай, захиргааны, үйлчилгээний албан хаагч нар дээр анхаарал хандуулж явж байгаа учраас өнөөдөр нэл дэлгэрэнгүй яригдсангүй. Энэ зүйлүүдээ бид нар бас олон нийтэд их зөв ойлгуулж байх ёстой юм байна лээ шүү. Тэгэхгүй бол буруу зөрүү зүйл. Жишээ нь 13 оноос хойш хүн ам нэг 1.5%-аар өссөн байхад төрийн албан хаагчдын тоо нэ 0,9%-аар өссөн байгаа юм. Тэгээд энэ тайлбаруудаа бид нар би яагаад ингэж ярьж байна гэхээр төрийн албанд гомдолтой шүүмжлэлтэй ханддаг юм их

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 05-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

байгаа. Үнийг ойлгож байгаа. Гэхдээ үүний хажуугаар үүнийг далимдуулаад, төрийн алба, төрд итгэх итгэлд зориуд буруу зөв ойлголт өгөх, суурь тавих ийм зүйлүүд байж болохгүй. Энэ үүднээс бид нар энэ өсөлт нь юун дээр илүү гарав гэдэг дээр, цаашидаа энэ захиргааны, улс төрийн албан хаагчдын тоог бууруулах тал дээр ялангуяа төрийн өмчийн оролцоотой байгууллагуудын тоог бууруулах гэх мэтчилэн энэ нийгэмд тулгамдаад байгаа асуудлууд дээр илүү анхаарах нь зүйтэй гэдэг дээр чуулган дээр ярихдаа бас ТАЗ-ийнхөн маань танилцуулах нь зүйтэй болов уу гэж бодож байна. Ер нь бол амаргүй ажил. Уг нь 93 оноос эхлээд энэ төрийн албыг эдийн засгаас, бизнесээс тусгаар байлгах тал дээр суурь болгосон энэ төрийн албаны шинэчлэл явагдсан. Харамсалтай нь жилээс жилд, сонгуулиас сонгуульд энэ асуудал хойшилсоор байгаад өнөөдөр жишээ нь төрийн албаны албан тушаалтнууд бизнесийн байгууллагуудын ТУЗ-д орчихсон сууж байна. Улс төр, бизнес 2 хутгалдаж байна гэж яриад байгаа юмнууд алхам алхмаар тэр анхны 92, 93 оноос хойш эхэлсэн шинэчлэлийн эрч буураад сүүлдээ ер нь бараг нөгөө тийшээ явах тал руу хандах гээд байгаатай бас холбоотой шүү гэдгийг бид нар бүгдээрээ ойлгох ёстой юм байгаа юм.

Харин сүүлийн үед энэ ЗГ-ын зүгээс энэ тал дээр анхаарч ажиллаж байгаа нь тэр анхны зах зээлийн эдийн засагт нийцсэн төрийн албыг илүү сайжруулалт, төлөвшүүлэлт тал руугаа дахиад анхны тэр үзэл агуулга, үзэл баримтлал руу хандаж байна уу гэсэн ийм чиглэлүүд байгаа.

Төрийн албаны ажил бол сая Занданишатар дарга ч хэллээ. Энэ үнэхээр олон зүйлээс үр дүн нь шалтгаалдаг. Цогцоор асуудлыг нь шийдэхгүй бол ганцхан ТАЗ ч юм уу ганцхан ЗГ-аас хамаараад байдаг зүйлүүд биш. Энэ ЗГ дээр сүүлийн үед бас энэ төрийн албатай холбоотой нэлээд зүйлүүдийг бодож, сэдэж, дотроо бүтэц зохион байгуулалт

бий болгож ажиллаж байгаа юм билээ. Тэгээд төрийн албаны ер нь алийг нь яг төрийн албаны биеэ даасан байгууллага хариуцаад явж байх вэ. Алийг нь эцсийн дүндээ ажил олгогчийн хувьд ЗГ хариуцаад явах вэ гэдэг дээр бодлого гаргаад бас тодорхой зүйлүүд хийгээд явж байгаа юм байна лээ. Үүнийг бид нар цааши цаашийн ажилдаа харгалзаж үзэж уялдуулж явж байх хэрэгтэй байна. Жишээ нь төрийн албаны төв байгууллагын хувьд бол шалгалтуудаа зохион байгуулах, сонгон шалгаруулалт, томилгоо, албан тушаал ч бууруулах, чөлөөлөх, халах, сахилгын шийдвэр ноогдуулах, үр дүнг нь үнэлэх, цалин хөлс, нөхцөл, баталгааны талаар гарсан гомдол маргааныг шалгах, хянан шийдвэрлэх, саналаа өгч байх ийм голдуу чиглэлээр нь явах нь зүйтэй болов уу гэж ЗГ-ын одоогийн яригдаж байгаа концепц дотор яригдаж байгаа юм байна лээ.

ЗГ нь бол яг хүний нөөцийнхөө удирдлага, зохицуулалт, төлөвлөлт, гүйцэтгэл, судалгаандаа илүү анхаарах нь зүйтэй юм байна гэсэн ийм байдлаар ажиллаж эхэлж байгаа юм байна. Тэгэхээр бид нар ялангуяа манай ТББХ-оос энэ зүйлүүдийг бас тухай тухай үед нь ороод ирэхэд нь судалж, хууль тогтоомжид тэгвэл ямар нэмэлт, өөрчлөлт орох юм гэдэг дээр нь бас анхаарч ажиллах ийм шаардлага байгаа.

Би зүгээр өнөөдөр манай Байнгын хорооноос дүгнэлт санал юм гарахгүй. Чуулганд танилцуулах тухай байна. Сайн, муугийн тухай дүгнэлтийг эцэслэж чуулган гаргах нь зүйтэй гэж бодож ер нь тэр хувийн байр сууриа илэрхийлэхэд гомдол их байдаг. ТАЗ бол 1 шүдгүй арслан шиг болчхоод байна. Тэгэхээр үүнийг 1 талд нь гаргаж шийдэх хэрэгтэй гэж. Энэ бас энэ зөвлөлийн зүгээс тавьж байгаа зөв шаардлагуудыг нь зөв шүүмжлэлүүдийг нь 1 гэж боддог. Тэгэхээр одоо үүнийг бид нар ЗГ-аас хэрэгжүүлэх гэж энэ эхэлж байгаа ажилтай нь уялдуулаад шүд нь хаанаа байх юм, тийм ээ, гэдгийг зохицуулах ийм

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 05-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

шаардлага ийм зохицуулалт хийх шаардлага байгаа. Энэ дээр ажиллах ёстой.

Монгол Улсын Ерөнхий сайд хүн би 1 ч хүн томилж болдоггүй юм байна эрхгүй байдаг юм байна гээд явж байсныг бид нар бүгдээрээ мэдэж байгаа. Ялангуяа бизнестэй холбоотой асуудлуудаар. Тэгэхээр энэ бол тэр төрийн албаны шинэчлэлийн анхны концепцтой зөрсөн тийм шаардлагыг Ерөнхий сайд хүн яриад явж байна гэдэг бол бид нар анхныхаа зорилтоос бас тодорхой хэмжээгээр ухраад ерөөсөө яамны хэмжээнд төрийн албаны юмнуудыг ялангуяа бизнестэй холбоотой юмнуудыг шийдэж байх шаардлага байна гэж хэлсэнтэй агаар 1 тийм юм яриад явж байсан байхгүй юу. Тэгээд энэ энэ гээд олон зүйлүүдийг зохицуулах шаардлага бий. Тухайлбал тэр яамнууд бодлогоо гаргадаг. Хэрэгжүүлэх гүйцэтгэдэг агентлагууд нь гол зүйлүүдээ хийдэг. Энэ анхны концептоосоо бид нар их ухрах шаардлага байхгүй. Үүнтэй л холбогдсон төрийн албаны бүтэц, зохион байгуулалт, зарчим, юмнуудыг цаашидаа үргэлжлүүлээд явбал хэрэгтэй гэсэн ийм бодолтой байгаа. Амаргүй ажил байдаг. Тэгэхдээ ТАЗ бол энэ хугацаанд ерөнхийдөө хэдийгээр ЗГ-ын зүгээс, улс төрийн зүгээс, элдэв шахалт дарамтууд байдаг. Жишээ нь тэр Идэрчулуун гишүүний ярьж байгаа юман дотор тодорхой харагдаж байна шүү дээ. Ийм байдаг ч гэсэн ямар ч байсан өнөөдөр хүчин төгөлдөр мөрдөж байгаа ТАЗ-ийн тухай төрийн албаны тухай хуулийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулж ирсэн. Зарим алдаа дутагдал дутуу байсан юмнууд байгаа байх. Гэхдээ хууль хэрэгжүүлэх тал дээр магадгүй зарим талаар ЗГ гүйцэтгэх засаглалын байгууллагуудтай санаа, оноо зөрөөд хүртэл яваад ирж байсан зүйл байгаа гэдгийг бид нар хэлэх хэрэгтэй.

Тэгээд энэ эцсийн дүгнэлт хэрэв дүгнэлт гаргана гэвэл чуулганы нэгдсэн хуралдаанаас гаргана биз. Бид нар

өнөөдөр гишүүдээс гарсан санал асуултынхаа хүрээнд ийм хэлэлцүүлэг боллоо гэдгийг нь тэмдэглээд УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанд оруулж тайланг дахиж хэлэлцэнэ ээ.

Санал, дүгнэлтийг Оюунчимэг гишүүн танилцуулчих уу, эндээс гарах санал дүгнэлтийг.

Өнөөдөр хэлэлцэх асуудал дууслаа. Байнгын хороогоор.

Оролцсон ажлын хэсгийн гишүүд, гишүүддээ баярлалаа.

Хуралдаан дууслаа.

Дууны бичлэгээс буулгасан:

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

П.ОЮУНГЭРЭЛ